



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМ



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг

Үндэсний түшиц



БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН

Орон нутгийн хэрэгжүүлэгч



ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
БОЛОВСРОЛЫН САН (FEE)-ИЙН
ГИШИҮҮН

БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЭДЭЭЛЭЛ СУРГАЛТЫН
ТӨВ НҮТБ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ II ТӨСӨЛ

Улирал тутмын цахим сонин


Дугаар №4

2021 оны 3 дугаар улирал

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД:

- СУРАГЧИД
ХОЁР ЖИЛД
ХИЧЭЭЛИЙНХЭЭ
45-68 ХУВИЙГ
ЦАХИМААР
СУРАЛЦЛАА
- СУРГУУЛИЙН
СЭТГЭЛ ЗҮЙЧИД
АЖИЛДАА ОРЛОО
- ТЭГШ
ХАМРУУЛАХ
ЗАРЧИМД
СУУРИЛСАН
“НОГООН
ГЭРЭЛ” ҮЙЛ
АЖИЛЛАГААГ
ХЭРЭГЖҮҮЛНЭ
- “ТЭГШ ХАМРАН
СУРГАЛТ-
ЧАНАРТАЙ
БОЛОВСРОЛ”
ЗОЧНЫ
ЯРИЛЦЛАГА
- ТХБ-II ТӨСЛИЙН
ТҮШИЦ ОРХОН
АЙМАГ МЭДЭЭЛЖ
БАЙНА
- ТЭГШ
ХАМРУУЛАХ,
ЯЛГААТАЙ
СУРАЛЦАХҮЙН
АРГА ЗҮЙГЭЭС
ТАНИЛЦУУЛАХ НЬ

СУРАГЧИД НИЙТ СУРГАЛТЫНХАА 45-68 ХУВИЙГ ЦАХИМААР СУРАЛЦЛАА



Энэ бол сүүлийн хоёр жилийн дундаж үзүүлэлт юм. Ковид-19 цар тахалтай холбогдуулан авсан хөл хорионы улмаас 2020 оны хичээлийн жилд сурагчид 75 өдөр буюу 15 долоо хоног, нийт сургалтын 45-47 хувьд зайнаас суралцсан байна.

Харин 2021 онд орон нутгийн сурагчид 100 өдөр буюу 20 долоо хоног, нийт сургалтынхаа 62 хувь, нийслэлийн сурагчид 110 өдөр буюу 22 долоо хоног, нийт сургалтынхаа 68 хувийг зайнаас суралцлаа.

КОВИД-19 цар тахлын үед буюу өнгөрсөн хоёр жилд улсын хэмжээгээр нийт багш, сурагчид 5284 теле хичээл бэлтгэн дохионы хэлний орчуулгатайгаар телевизээр гаргажээ. Мөн 104 интерактив хичээл, 2 775 цахим хичээл, 50 цахим контент, 30 радио болон аудио хичээл бэлтгэн econtent.edu.mn бусад цахим сангаар сурагчдад хүргэлээ гэж Боловсролын хүрээлэн мэдээллээ.

СУРГУУЛИЙН СЭТГЭЛ ЗҮЙЧИД АЖИЛДАА ОРЛОО

Энэ хичээлийн жилээс эхлэн төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулиуд сэтгэл зүйчтэй болж байна. Боловсролын сэтгэл зүйчдийг мэргэшүүлэн бэлтгэх сургалт, үйл ажиллагааг БШУЯ, Тогтвортой хөгжлийн боловсрол-II төслийн үндэсний түшиц байгууллага Боловсролын хүрээлэн, орон нутгийн хэрэгжүүлэгч Байгаль орчны мэдээлэл сургалтын төв, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт болон Монголын сэтгэл зүйчдийн нийгэмлэг хамтран энэ оны 03 дугаар сараас зохион байгуулж эхэлсэн. Одоогоор нийт 72 боловсролын сэтгэл зүйч бэлтгэгдэн ажилдаа ороод байна.



Тэд “Боловсролын сэтгэл судлал”-ын 12 багц цагийн сургалтыг Монголын сэтгэл зүйчдийн нийгэмлэгийн мэргэжлийн сургагч багш, салбарын эрдэмтэн судлаачдаар заалгаж, мэргэжлийн байгууллагуудад дадлага хийжээ. Энэ хичээлийн жилд боловсролын сэтгэл зүйчид ментор багшийн зөвлөмж удирдлагаар ажиллах юм байна.

Холбогдох мэдээлэл, ярилцлагыг ТХБ-ХАМТЫН АЖИЛЛАГАА нүүрнээс уншаарай

ДОХИОНЫ ХЭЛНИЙ ЦАХИМ ОРЧУУЛГЫГ МОНГОЛД 4000 ОРЧИМ ИРГЭН ХЭРЭГЛЭЖ БАЙНА

Жил бүрийн 9 дүгээр сарын 23-ны өдөр Олон улсын дохионы хэлний өдрийг тэмдэглэдэг уламжлалтай. Сонголын бэрхшээлтэй иргэдийн Дэлхийн холбоо (WFD)-ны анхны конгресс 1951 оны есдүгээр сард Италийн Ром хотноо чуулж байсантай холбогдуулан энэ сарын сүүлийн өдрүүдийг Олон улсын сонсголгүй иргэдийн долоо хоног болгон 1958 оноос эхлэн тэмдэглэдэг болжээ. Энэ жил тус өдрийг дэлхий нийтээрээ “Өөдлөн дэвжсэн сонсголгүй олон нийтийг алдаршуулъя” уриатай тэмдэглэж буй. Манай улс 12 дахь жилдээ энэ өдрийг тэмдэглэж байна.



Дохионы хэл бол сонсголын бэрхшээлтэй иргэдийн төрөлх хэл. Манай улс ч холбогдох хуулиндаа ингэж заасан байдаг. Тиймээс дохионы хэлээр түгээмэл харилцаж сурах нь тэдний эрхийг хангаж буй гол хэлбэр юм. Гэвч эх хэлээрээ боловсрол эзэмшиж, орчуулгын үйлчилгээ авах боломж нөхцөл тааруу. Хууль хяналтын болоод бусад албан үйлчилгээнд энэ төрлийн хэлмэрч, хэлмэрчдийн төсөв хөрөнгө дутагдсан хэвээр байгааг сонсголын бэрхшээлтэй иргэд, мэргэжлийн холбоод хэлж байгаа юм.

Монголын Дохионы хэлний орчуулагчдын холбооноос гаргасан “Дохионы хэлний видео дуудлага” цахим орчуулгын үйлчилгээг одоогоор улсын хэмжээнд 4000 гаруй хүн хэрэглэж байна.

“ШИНЭ ЭХЛЭЛ” СУРГУУЛЬ ЦАХИМ ТӨВӨӨ БАЙГУУЛЛАА



ТХБ-II төслийн түшиц сургуулийн нэг, олон улсын хөтөлбөрийн сургалттай, нийслэлийн ерөнхий боловсролын “Шинэ эхлэл” сургууль “Тогтвортой хөгжлийн боловсролын цахим төв”-өө байгуулаад байна. Тогтвортой хөгжлийн боловсролын цөм агуулгын хүрээнд интеграци хичээлийн агуулга, арга зүйн шийдэл бүхий нэгдмэл агуулгад суурилсан хөтөлбөр боловсруулан, сургалтын багц хэрэглэгдэхүүн, контентууд бэлтгэж цахим төвдөө байршуулахаас гадна сургалт, үйл ажиллагаандаа ашиглана. Тус сургуулийн багш, сурагчид, холбогдох албаны хүмүүстэй хамтран тэдгээр хэрэглэгдэхүүн, видео контентуудаа дээрх төслөөр байгуулсан студидээ бэлтгэж эхэллээ.

Мөн ТХБ-II төслийн хүрээнд сургууль бүхлээр ажиллах арга хандлагыг сургуулийнхаа үйл

ТХБ-МЭДЭЭ

ажиллагаанд амжилттай нэвтрүүлж байгаагаа “Шинэ эхлэл” сургуулийн захирал Н.Оюунгэрэл онцоллоо. “Сургуулийн үйл ажиллагааг зөвхөн удирдлагууд төлөвлөх биш сурагч, эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтнуудынхаа хамтаар төлөвлөж, дүүргийн удирдлагууд, хорооны иргэд, эцэг эхийн төлөөлөл, сурагчдын хамтын оролцоотой хэрэгжүүлэхэд анхаарч байна. Мөн сурагчдаа үе тэнгийн сургагчаар бэлтгэж эхэллээ. Тэд ТХЗ-уудын агуулгын хүрээнд мэдэж, хэрэгжүүлж дадсан бүхнээ үеийнхэндээ зааж, түгээн дэлгэрүүлнэ” гэлээ.

Тус сургууль өнгөрсөн тавдугаар сараас “Хамтдаа хөгжье” аянаа дөрвөн үе шаттай хэрэгжүүлж эхэлжээ. Зөв амьдралын хэвшлийг өөрөөсөө эхлэх, дараа нь гэр бүл, хамт олноороо хамтран оролцож, сайн арга туршлага, ахиц амжилтаа олон нийтэд түгээн дэлгэрүүлж, бусдад нөлөөлөх нь энэ аяны зорилго юм байна.

БОАЖЯ, БШУЯ, ШХА-ын хамтран хэрэгжүүлж буй ТХБ-II төсөлд нийт 30 сургууль хамрагддаг бөгөөд сургуулиудыг Байгаль орчны мэдээлэл сургалтын төв чадавхжуулан ажиллаж байна.

ЭМИЙН НЭН ХОВОР УРГАМЛЫГ ТАРИМАЛЖУУЛЖ БАЙНА



МУБИС-ийн “Ургамлын судалгаа, сургалт арга зүйн төв” нь сургалт, судалгаа, туршилтын зориулалтаар нэн ховор, ховор эмийн, чимэглэлийн 16 овгийн 48 зүйлийн ургамлуудыг тарьж ургуулаад байна.

Үүнд эмийн гол түүхий эд болох нарийн навчит цахилдаг, их шүүдэргэнэ, чихэр өвс, лидэр зэрэг ургамал орж байна. 2017 онд байгуулагдсан тус төв багш, оюутан, сурагчдад тогтвортой хөгжлийн боловсролыг олгох, байгалийн ургамлын төрөл зүйлийг хамгаалах, эмийн болон ашигт ургамлыг тарималжуулах, нутагшуулах арга зүй эзэмшүүлэх зорилгоор монгол орны байгалийн ургамлыг тарималжуулах, нутагшуулах судалгааг сүүлийн таван жил тасралтгүй хийжээ.

Дээрх төвийн эрхлэгч, биологийн ухааны доктор Я.Гэрэлчулуун ярихдаа “Бид өөрсдөө хэрэглээ өндөртэй ургамлуудыг тарималжуулж ашиглах бүрэн боломжтой. Зарим байгууллагууд ч тарьж ургуулан ашиглаж эхэлсэн. Хэрэв бид дандаа байгалиас түүгээд байвал тухайн ургамал устана. Ингэснээр байгалийн төрөл зүйл устаж, экологийн тэнцвэрт байдал алдагдана.” гэлээ. 2011 онд Монгол орны ургамлын дансанд хамгаалах шаардлагатай 55 зүйл хамаарагдаж байсан бол 7 жилийн дараа гурав дахин нэмэгдсэн байна.


ГАРЧИГ

ДОТООД МЭДЭЭ	1-2
ХАМТЫН АЖИЛЛАГАА	3
НЭГ СЭДВЭЭР	4-5
ЗОЧИН	6
БИД	7
ОРОН НУТАГ	8



“ТХЗ-ЫН ТӨЛӨӨХ БОЛОВСРОЛЫГ СУРАЛЦАХУЙД ИНТЕГРАЦЧИЛАХ АРГА ЗҮЙ” БАГШИЙН ГАРЫН АВЛАГА-БАГЦ НОМ ДАХИН ХЭВЛЭГДЛЭЭ

Багц номоор 1972 оноос хойших дэлхий нийтийн тогтвортой хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролын түүхэн замнал, үйл явцын өрнөл, тэдгээрийн зорилго, агуулга, арга хандлагын интеграцыг НҮБ-ын тулгуур



баримт бичгүүдэд үндэслэн тоймлож бүхэлд нь харах, улмаар түүний Монгол улс дахь тусгалыг тольдох боломжийг уншигчдад олгож байна. Мөн багш нарт ТХЗ-д хүрэх агуулга, арга техникийг анги, судлагдахуун бүрийн хичээл болон сургалтын үйл ажиллагаанд интеграцчлах боломжуудыг харуулахыг зорьжээ.

Боловсролын түвшин тус бүрээр “Тогтвортой хөгжлийн боловсролыг суралцахуйд хэрхэн интеграцчлах арга зүйг тусгаснаараа ЕБС-ийн удирдах ажилтан, багш нарын ширээний ном болно гэж үзэж байна.

"ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТӨЛӨӨХ ЭЗЭГТЭЙ НАР" СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

"Тогтвортой хөгжлийн боловсрол-II" төслийн хүрээнд МУБИС-ийн Тогтвортой байдлын түр хороо байгууллагын ээлжит сургалтаа "Тогтвортой байдлын төлөөх эзэгтэй нар" сэдвээр зохион байгууллаа. Хэт их хэрэглээний хандлагыг өөрчлөх, байгальд хөнөөлгүй эрүүл бүтээгдэхүүнийг өөрөө бэлтгэж, гэр бүлийнхээ хэрэгцээг хангах талаар багш, ажиллагсдынхаа төлөөлөлд зааж, нэг өдрийг бүтээлчээр үдлээ.

7 дугаар сарын сургалтад тус сургуулийн Эрдэм шинжилгээ, инновацийн албаны дарга Я.Шийлэгмаа, Гадаад харилцааны



албаны дарга Д.Үүрийнтуяа нар “Хандлагаа өөрчилбөө–хувь нэмрээ оруулъя” сэдвийн хүрээнд ажил, амьдралдаа хэрэгжүүлж буй туршлагаа хуваалцаж, мэдээлэл солилцлоо. Я.Шийлэгмаа “Бид өөрөөрөө үлгэрлэж, хамт олон, гэр бүл, найз нөхдийн хүрээнд нөлөөлөх боломж бүрэн байна. Жишээ нь гэртээ хогоо ангилан ялгаж хотхоныхоо хог ангилан ялгах цэгт хаядаг болсноор гэрээс хог бараг гарахаа больсон. Ингээд бидний хог дахин боловсруулах хаягдал болохыг ойлгож авсан. Хог хаягдлаа дууссан Швед улс хөрш зэргэлдээх улсаасаа хог нь авч дахин боловсруулж байна. Манайд хүн бүр хогоо ангилан ялгах хэвшилтэй болсон цагт энэ улсын жишгээр хогоо баялаг болгох бүрэн боломжтой” гэж байлаа.

Сурвалжилга

ТЕЛЕ, ЦАХИМААР ХИЧЭЭЛЛЭСЭН БАГШ, СУРАГЧИД ХОЁР ЖИЛИЙН ДАРАА...

Ковид19 цар тахлын улмаас хоёр жил шахам зайнаас хичээллэсэн багш, сурагчид энэ хичээлийн жилд цахим, танхимыг хослуулан хичээллэж эхлээд байна. Өнгөрсөн цаг хугацаа сурагч, багш нарт ямар сургамж үлдээсэн бол?



Нийслэлийн СХД-ийн 122 дугаар сургуулийн биологийн багш

Ч.ЭРДЭНЭЦЭЦЭГ: ЗАЙНААС СУРАЛЦАХ АРГА ТЕХНОЛОГИД СУРАЛЦСАН

-Хоёр хичээлийн жил сургуулийн үйл ажиллагаа цахимаар явлаа. Энэ хугацаанд сайн, саар талууд цөөнгүй л бий болсон байгаа даа?

Дэлхий нийтийг хамарсан цар тахал боловсролын системд эерэг, сөрөг нөлөөг үзүүлсэн. Эерэг тал нь багш бид зайнаас хичээлээ заах арга техникт суралцлаа. Хүүхдүүд маань ч цахим хичээлдээ дадаж, суралцаж байна. Эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ ажиллах цаг хугацаагаа нэмэгдүүлсэн зэрэг эерэг тал бий. Миний хувьд ургамал ногоогоо хэрхэн тарьж ургуулахыг өөрөө видео бичлэгээр үзүүлээд хүүхдүүдээ яаж хийж байгааг харчхаж байгаа юм. Зарим эцэг эхчүүд тодруулж асуух зүйлээ манайд ирээд асуугаад явсан тохиолдлууд ч бий.

Сул тал нь амьд харилцаа байхгүй учраас хүүхдүүд багш нараасаа, найз нөхдөөсөө хөндийрөх янзтай. Мөн биологич мэргэжил сонгох хүүхдүүдтэй нэг бүрчлэн тулж ажиллахгүй бол амжилтад нөлөөлөх тал бий.

-Цаашид цахим хичээлийг илүү үр дүнтэй болгохын тулд юуг анхаарах шаардлагатай гэж бодож байна?

Манай хүүхдүүд Германд амьдардаг. Тухайн улсад нэг долоо хоног нь цахимаар, нэг долоо хоног нь танхимаар ордог гэсэн. Багш, хүүхдүүд нь бүгд зайнаас суралцах арга технологид суралцсан. Хүүхэд бие даан суралцах систем нь бүрэн хөгжсөн учраас манайхтай харьцуулахад их үр дүнтэй байгаа юм шиг санагдсан.

Тэгэхээр цаашид багш нарын компьютерыг шинэчилж, бусад шаардлагатай сургалтын материалаар хангаж өгөх хэрэгтэй. Өнөөдрийн байдлаар улсаас өгсөн компьютер нь чанарын шаардлага хангахгүй, сургалтын материалаа өөрсдөө авч, дата бусад зардлаа өөрсдөө хариуцаж байгаа болохоор ихэнх багш нарт хүнд байна.

Мөн бид олон жил ярьж байгаа сурагчийн бие даан суралцах, хөгжих боломж нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй.



Нийслэлийн СХД-ийн 122 дугаар сургуулийн 116 ангийн сурагч

Л.ЛХАГВА: ХЭВИЙН БАЙДАЛДАА ОРОХЫГ ХҮЛЭЭЖ БАЙНА

Хичээл танхимаар орж эхэлснээр ангийнхан, найзууд, багш нартайгаа уулзаад гоё байна. Хамгийн гол нь хичээлээ ойлгоход, хичээлээс гадуурх дугуйланд явж өөрсдийгөө хөгжүүлэх боломж нь хумигдсан юм шиг санагдсан.

Миний хувьд сургуулийнхаа “Эко клуб”-ын гишүүн нь. Бид байгаль орчин ямар тохиолдолд доройтдог вэ гэдгийг сайн мэддэг учраас хог хаях болон бусад байдлаар байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхийг хүсдэггүй. Ковидын өвчлөл буураад хичээл сургуулийн үйл ажиллагаа хэвийн үргэлжлэвэл “Эко клуб”тээ шинэ гишүүдээ элсүүлж, клубээрээ, ангиараа аялалд явахыг хүсэж байна даа.



Нийслэлийн БГД-ийн 28 дугаар сургуулийн сургалтын менежер

Ц.МЯГМАРЖАВ: ЦАХИМ БОЛОН ТАНХИМААР ХИЧЭЭЛЛЭЖ БАЙГАА ҮЕД ХОЦРОГДЛЫГ АРИЛГАХАД ХҮНД

Нэг ангийн хүүхдүүдийг хоёр хуваагаад хоёр өөр долоо хоногт хичээллүүлэхээр багшид ачаалал нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл, багш долоо хоногт 20 цаг орох байтал 40 болж нэмэгдэнэ. Тиймээс багш цахим хичээлээ заахдаа зургадугаар ангийн таван бүлгийн 200 хүүхэд байлаа гэхэд бүгдэд нэг л удаа ороод явах боломжийг бүрдүүлсэн. Манай багш нар цахим хичээлээр нэлээд сайн суралцаж, туршлагаадаа байна.

Багш нарын өгч байгаа мэдээллээр хоцрогдол их байна. Цахим болон танхимаар оролцож байгаа энэ нөхцөлд хоцрогдлыг нөхөхөд төвөгтэй. Тухайлбал, долоо хоногт хоёр цаг ордог хичээл нэг улиралд 32 цаг орох ёстой. Одоо бол нэг долоо хоног нь хоёр цаг үзээд дараагийн долоо хоног нь нэг цаг үзэж байна. Ингэхээр 24 цаг болж байгаа юм. Дээрээс нь багш хүүхэд нэг бүртэй тулж ажиллах боломжгүй учраас хоцрогдлыг нөхөхөд хүндрэлтэй болов уу.



Нийслэлийн БГД-ийн 28 дугаар сургуулийн 5а ангийн багш

М.БАТЗАЯА: МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛЭЭ ЭХНЭЭС НЬ ЗААЖ БАЙНА

Өнгөрсөн хоёр хичээлийн жилд багш нар аль болох ойлгомжтой байдлаар хичээлээ бэлтгэж сурагчиддаа заасан. Гэсэн ч хичээлийг

ойлгох, өөрийн болгож авах тал дээр сул байсан нь өнөөдөр мэдэгдэж байна.

-Хичээлийн хоцрогдол их байна гэсэн үг үү.

Тийм ээ. Манай хүүхдүүд хүрдээ бүрэн цээжлээд нэг сая тоон дотор бодох, тоймлох аргад суралцсан байх ёстой. Гэтэл энэ хэмжээний хүүхэд манай ангид хуруу дарам цөөн байгаагаас харж болно. Цаашлаад монгол хэлний хичээл дээр юу зааж байсан тэр хэмжээндээ л байна. Өөрөөр хэлбэл, дүрмээ эхнээс нь заагаад л сууж байна. Тэгэхээр теле хичээл, цахим хичээлийг бага ангийн хүүхдүүд маань тэр бүр ойлгохгүй байгаа нь ажиглагдлаа. Мөн эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ хэрхэн харилцаж байсан нь хүүхдийн сурлагаас харагддаг.



Булган аймгийн Хишиг-Өндөр сумын ЕБС-ийн 36 ангийн багш

Д.БОЛОРТУЯА: ХҮҮХДҮҮД МААНЬ ХОЁРДУГААР АНГИДАА ЮУ ЗААЖ БАЙСАН ТЭР ХЭВЭНДЭЭ Л БАЙНА

Манай ангийн хүүхдүүд нэгдүгээр ангидаа хагас хичээлийн жил, хоёрдугаар ангидаа хоёр сар танхимаар сураад бусад хугацаанд теле болон цахимаар хичээлээ үзсэн. Хүрдээ бүрэн цээжлээд нэмэх хасахаас гадна үржүүлж хуваагаад сурчихсан байх ёстой. Хүүхдүүд маань харилцан адилгүй байна. Аав ээж, ах эгч нар нь сайн ажилласан хүүхдүүд сайн байна. Дийлэнх нь хүрдээ цээжлээгүй, зөв, хичээнгүй бичиж чадахгүй л байна.



Булган аймгийн Хишиг-Өндөр сумын ЕБС-ийн Физикийн багш

Ц.САРАН: ХӨДӨӨД ЦАХИМ ХИЧЭЭЛИЙН ХАМРАГДАЛТ МАШ МУУ БАЙСАН

Манай сургуулийн сурагчдын дийлэнх нь малчны хүүхдүүд. Тэд сумын төвөөсөө хол сүлжээгүй газар байдаг. Энэ утгаараа цахим хичээлд суух нь ховор. Нэг ангид цахим хичээл заахад 4-5 хүүхэд л орж ирдэг. Бусад нь хөдөө, сүлжээгүй утасгүй гэх шалтгаанаар тэр чигтээ байхгүй. Теле хичээлээ л алдаг оног үзсэн байгаа юм. Ийм нөхцөлд хичээлийн хоцрогдол их байх нь ойлгомжтой. Бусад хөдөө орон нутагт яг л ийм байна. Манай багш нар хавар малчдын хотоор явсан. Ахлах ангийн хүүхдүүд юун хичээл манатай, малын ажилдаа туслаад түмэн завгүй гүйж яваа харагдсан. Эндээс юу ажиглагдаж байна вэ гэхээр цахим сургалтаар хөдөө орон нутгийн хүүхдүүдэд боловсрол олгоно гэдэг өнөөдрийн нөхцөлд хүндрэлтэй. Харин хүүхдүүдэд дотуур байрандаа аваад зайнаас сургана гэвэл үр дүнтэй байж болохоор харагдаж байна. Сая хичээл эхлэхэд дотуур байранд ах эгч нар нь дүү нартаа хичээлийг нь зааж өгөөд, бүгдээрээ хичээлдээ идэвхтэй оролцож байгаа нь харагдсан.

"ТХБ-ХАМТЫН АЖИЛЛАГАА" нүүрэнд: Монгол улсад боловсролын салбарын сэтгэл зүйчдийг хамтран бэлтгэсэн үйл явдлыг онцоллоо.

Ярилцлага

Ш.БАТСҮХ “ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХОД СЭТГЭЛ ЗҮЙЧИД ГОЛ ҮҮРЭГТЭЙ”

Нийт төрийн өмчит 670 гаруй ерөнхий боловсролын сургууль байгаагаас энэ хичээлийн жилд “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” /ТХБ-II/ төслийн түшиц 30, олон улсын хөтөлбөртэй болон лаборатори 42, нийт 72 сургуульд мэргэшсэн сэтгэл зүйчийг ажиллуулахаар БШУЯ шийдвэрлэсэн.

Бид энэ ажлын хэсгийн ахлагч, Монголын сэтгэл зүйчдийн нийгэмлэгийн тэргүүн, БШУ-ны сайдын зөвлөх, доктор, профессор Ш.Батсүхээс зарим мэдээллийг тодруулж ярилцлаа.

Ерөнхий боловсролын сургуулиуд /ЕБС-д мэргэшсэн сэтгэл зүйч ажиллуулах бэлтгэл ажлын явцыг эхлээд тодруулъя?

БШУ-ны сайд Л.Энх-Амгалан өнгөрсөн гуравдугаар сард сэтгэл зүйчидтэй уулзаж, сургуулиудад сэтгэл зүйч ажиллуулах саналаа илэрхийлж, хамтарч ажиллах хүсэлт тавьснаар энэ ажил эхэлсэн. Нийт 839 ЕБС байгаагаас 670 нь улсын, бусад нь хувийн хэвшлийнх. Салбарын яам 2024 оныг дуустал боловсролын сэтгэл зүйчдийг бодлогоор бэлтгэж, бүх сургуульд ажиллуулах зорилт тавьсан. Эхний ээлжид 72 сургуульд мэргэшсэн сэтгэл зүйчдийг ажиллуулах боломжтой боллоо. Одоогоор ерөнхий боловсролын 70 гаруй сургууль /хувийн хэвшлийн/ сэтгэл зүйчдийг ажиллуулж байна.

Гуравдугаар сараас хойш бид олон ажил хийлээ. ЕБС-д багш, эцэг эх, асран хамгаалагч, хүүхдэд үзүүлэх сэтгэл зүйн үйлчилгээний ойрын болон дунд хугацааны төлөвлөгөө, тайлан, зөвлөмжүүд боловсрууллаа. Сургалтын хөтөлбөрөөс авахуулаад албан тушаалын тодорхойлолт, ёс зүйн дүрэм, үйл ажиллагааны журам гээд олон бичиг баримт боловсруулж, судалгаа хийсэн. Дараа нь сэтгэл зүйчдээ хоёр үе шатаар шалгаруулж, 70 гаруй хүнийг мэргэшүүлэх сургалт зохион байгуулж байна. Мэргэшүүлэх 45 хоногийн сургалтыг төгссөн сэтгэл зүйчдийг шууд сургууль дээр очиж ажиллах хэмжээний мэдлэг чадварыг олгох гэж хаа хаанаа хичээлээ. Туршлагатай олон сэтгэл зүйчид, багш нар хичээл заасан.

Боловсролын сэтгэл зүйчид ажиллуулах сургуулиудаа хэрхэн сонгосон бэ?

ТХБ-II төслийн түшиц 30 сургууль, дээр нь БШУЯ-ны харьяа лаборатори болон ОУ-ын хөтөлбөртэй сургууль гээд хоёр бүлгийн 72 сургууль дээр энэ ажил хэрэгжинэ. Энэ ажил нэлээд өртөг өндөртэй тул хөрөнгө төсөвтөө захирагдахын эрхэнд эхний ээлжид Швейцарын хөгжлийн агентлаг, “Бадамлин” ТББ хоёрын санхүүгийн дэмжлэгтэйгээр мэргэшүүлэх сургалтуудаа зохион байгуулж байна. Зарим хүмүүс яагаад заавал эдгээр сургуулиудыг сонгосон юм бэ гэсэн асуудал тавьдаг. Энэ бол цэвэр төсөв мөнгөтэй холбоотой. Ирэх оноос жил бүр 200 боловсролын сэтгэл зүйч бэлтгэх төлөвлөгөөг яам гаргаж төсвийн төлөвлөгөөндөө тусгасан. УИХ төсвийг нь бүрэн баталж өгвөл энэ ажил хэрэгжинэ.

Нэг сэтгэл зүйчийг боловсролын сэтгэл зүйчээр мэргэшүүлж бэлтгэхэд цагаар нь тооцвол 8-12 орчим сая төгрөг гарахаар байгаа юм. Нэг хүний бодит сургалтын төлбөр нь 1 сая гаруй

төгрөг, гарын авлага материал нь 1 сая 300 мянган төгрөг, дээр нь ажлын тоног төхөөрөмжийн зардал нэмэгдэж байна. Энэ бүх зардлыг Швейцарын хөгжлийн агентлаг, түүний санхүүжүүлдэг ТХБ-II төслөөс гаргаж, дэмжиж байгаад талархаж байгаагаа илэрхийлье. Харин сургуулиуд өөрсдөө өрөө тасалгаагаа гаргаж тохижуулж байна. БШУЯ-ны харьяа лаборатори болон олон улсын хөтөлбөртэй сургуулиудын төсвийг яам өөрөө мэддэг учраас орон тоо, цалингийн санг шийдэж байгаа. Эдгээр сургуулиудад ажиллах сэтгэл зүйчдийн сургалтын зардалд “Бадамлин” ТББ байгууллага дэмжлэг үзүүлж бидэнтэй хамтран ажиллаж байгаад бас их баяртай байна.

Тэгш хамруулсан, тэгш боломжийг хангасан чанартай боловсролоор бүх нийтийг хангахад сэтгэл зүйчийн үүрэг ямар байх вэ гэдэг нь эндээс харагдаж байгаа болов уу?

Боловсролын тэгш хамрагдалт гэдэгт хүнийг нийгэмд бэлтгэж байгаа маш том үзэл санаа яваад байгаа юм. Сэтгэл зүйчид эцэг эхчүүдэд “Та хүүхдээ хэн нэгэнтэй битгий харьцуулаарай” гэж захидаг.

Яагаад бүх хүний хурууны хээ ялгаатай байдаг вэ. Энэ нь тэр хүн өөрөө өвөрмөц онцлогтой цорын ганц бие хүн гэдгийг илтгэж байгаа хэрэг. Түүнийг хүлээн зөвшөөрч, зөв хөгжүүлэх явдал маш чухал. Үүнд сэтгэл зүйчид маш их үүрэгтэй. Бид тогтвортой хөгжилд чиглэсэн, зориулагдсан боловсрол эзэмшүүлэхийг зорьж байгаа шүү дээ. Үүний тулд өөрчлөгдөж байгаа дэлхийн ертөнцийн юмс, үзэгдлийг зөв хүртэж, хүлээж авч сурах, янз бүрийн бэрхшээлтэй орчинд өөрийгөө дасгаж даван туулах чадвартай болох, эрсдэл аюулыг даван туулах хүчтэй сэтгэл зүйтэй байх, байгаль орчин, хүрээлэн буй орчноо хайрладаг байх, хэн нэгнийг ялгаварлахгүй байх, хэвийн ажиллаж амьдрах чадвар эзэмших хэрэгтэй болж байна. Энэ бол тогтвортой хөгжлийн боловсролтой сэтгэл зүйчдийн ажил хэрхэн холбогдож байгааг илтгэж байгаа хэрэг.

Энэ бүхнээс ЕБС-ууд мэргэшсэн сэтгэл зүйчтэй байх үндэс суурь тавигдлаа гэж ойлгож болох уу?

Монголын хөгжлийн бодлогын урт хугацааны баримт бичиг “Алсын хараа 2050”-ийн “Хүний хөгжил” гэсэн 2 дугаар бүлэгт ерөнхий боловсролын бүх сургуульд сэтгэл зүйчид ажиллана гэж заасан. Энэ заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай болно. 2002 онд Бага, дунд боловсролын хуулинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй сургуульд сэтгэл зүйч ажиллуулна гэсэн заалт бий. Мөн өмнөх сайд нар ЕБС-дад сэтгэл зүйч ажиллуулах шийдвэр

суралгчдын сэтгэцийн эрүүл мэндийн ачааг дангаараа үүрэх албагүй. Үүнд, үндэсний, орон нутгийн, олон нийтийн түвшинд сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх бусад мэргэжилтэн, байгууллагуудтай түншлэх нь чухал.

Боловсролын сэтгэл зүйчид та бүхэн нийгмийг аюулгүй, эрүүл байлгаж, урьдынхаас илүү хүчтэй чадварлаг боловсролын системийг бий болгоход үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна” гэж Швейцарын хөгжлийн агентлагийн дэд дарга БЕНУА МЕЙЭР БИШ мэдэгдлээ.

Т.ОЙДОВЧИМЭД “СЭТГЭЛ ЗҮЙЧИЙН ТӨМӨР ШҮҮГЭЭНД ХУУЛИЙН АЖИЛТНУУД Ч ХАЛДАХ ЭРХГҮЙ”

"ШИНЭ ЭХЛЭЛ" ЕБС-ийн сэтгэл зүйч:

Сургуулийн сэтгэл зүйчээр мэргэшин суралцаж, ажиллах гэж байгаадаа баяртай байна. Бид оюутан байхдаа сургууль, цэцэрлэгт сэтгэл зүйч үнэхээр хэрэгцээтэй юм байна гэж тодорхойлоод энэ чиглэлээр судалгаа явуулж, дадлага хийдэг байсан. Миний хувьд энэ үеэс л мэргэжлээрээ хүүхдүүдтэй ажиллахыг хүсч байлаа. Сүүлийн жилүүдэд сэтгэл судлалын салбар юунд, ямар хэрэгтэйг хүмүүс ойлгож, сэтгэл зүйчдийг хүлээж авахад бэлэн болж байна.

Нэг жишээ ярья. Нэг сургуулийн дунд ангийн хүүгийн эцэг эх хүүхдэдээ хэлж мэдэгдэлгүй гэрээ нүүлгээд, сургуулийг нь шилжүүлсэн байгаа юм. Хүүхэд үүнээс болж маш их стресст орж, шинэ ангийнхан, багш нартайгаа их бухимдаж харилцааг болсон. Ингээд нэг өдөр ангийн багш нь, хүүгийн эцэг эх, хүү өөрөө надад зэрэг шахуу хандсан. Тэд бие биендээ мэдэгдээгүй, хоорондоо ярилцаж тохиролцоогүй, шууд л сэтгэл зүйчийг сонгосон байсан л даа. Бүгд өөрсдөө хүсч байсан болохоор асуудал хурдан хугацаанд амжилттай шийдэгдсэн. Хүү ч өөрчлөгдсөн. Орчин тойрныхон нь түүнийг ууртай, хэцүү хүүхэд гэж хаяглахаа больсон.

гаргасан байдаг. Гэвч хэрэгжээгүй. Төсөв мөнгө, орон тоог шийдэж, хэрэгжүүлэх ажлыг газар дээр нь зохион байгуулж өгөөгүйтэй холбоотой байх. Дээр дурдсанчлан БШУЯ ирэх 3 жилд жил бүр 200 сэтгэл зүйчийг боловсролын сэтгэл зүйчээр мэргэшүүлж сургахаар төсөв мөнгийг нь тавиад явж байгаа. УИХ энэ асуудлыг ойлгоод төсвийг нь батлах юм бол 2024 он гэхэд улсын мэдлийн 670 сургууль сэтгэл зүйчтэй болно. Одоо шинэчлэгдэн батлагдах Боловсролын багц хуулийн төсөлд мөн энэ санал тусаад явж байна.

АНУ-ын сэтгэл судлаач, алдартай эрдэмтэн Эрих Фромм “тухайн нийгмээ амжилттай хөгжүүлбэ гэвэл тэр нийгмийнхээ зорилгыг ойлгосон, тэр зорилгод чиглэсэн хүмүүсээ бэлтгэх ёстой. Эс чадваас тухайн нийгэм дампуурдаг” гэсэн санааг хэлсэн байдаг. Бид Үндсэн хуулиндаа хүмүүнлэг, ардчилсан, иргэний нийгмийг цогцлоон хөгжүүлэхээр өргөн агуулгатай зорилт дэвшүүлсэн. Энэ зорилтыг хэрэгжүүлэх тийм хүмүүсийг л хөгжүүлэх ёстой. Тэдэнд чухал дэмжлэг үзүүлэх хүмүүс нь сэтгэл зүйчид юм.

Боловсролын сэтгэл зүйчийн тогтолцоо нь боловсролын том тогтолцоонд цоо шинээр орж ирж байгаа нэгэн дэд тогтолцоо юм. Энэ тогтолцоог баттай төлөвшүүлэхэд тал талын хүчин чармайлт хэрэгтэй. Тийм учраас бид аймгийн Засаг дарга, аймгийн Боловсролын газрын дарга, сургуулийн захирлуудтай хэд хэдэн удаа цахим уулзалт хийж ойлголцсон. Өнөөдөр дэлхийн эрэлттэй 10 мэргэжлийн нэгд сэтгэл судлалын мэргэжил орж байна.

Манайд ер нь сэтгэл зүйч мэргэжилтнүүдийн нөөц ямар байна?

Манай улс 1992 оноос сэтгэл зүйчдийг бэлтгэж эхэлсэн. 2000 орчим сэтгэл зүйчдийг бэлтгэсэн гэсэн судалгаа байсан. Одоогоор нөөц байна. Цаашид бакалаврын түвшинд боловсролын сэтгэл зүйч бэлтгэхээр их дээд сургуулиуд элсэлтээ авч эхэллээ. Эрэлттэй байна гэж мэдээлж байсан. Гэхдээ энэ хүмүүсийг нэг удаа мэргэшүүлж сургаад орхичихгүй, давтан сургалтад байнга хамруулах ёстой. Цаашид бидний өмнө маш их ажил байна.

Баярлалаа.

БЕНУА МЕЙЭР БИШ “СУРГУУЛИЙН СЭТГЭЛ ЗҮЙЧИД БОЛ ТОГЛООМЫГ ӨӨРЧЛӨХ ХҮЧ МӨН”

Боловсролын сэтгэл зүйчдийг мэргэшүүлэн бэлтгэх сургалт, үйл ажиллагааг дэмжигч гол байгууллагын нэг нь Швейцарын хөгжлийн агентлаг юм. Тус агентлагийн дэд дарга БЕНУА МЕЙЭР БИШ боловсролын сэтгэл зүйчид, олон нийтэд хандан хэлсэн үгэндээ улс орон, бүс нутаг, дэлхий даяараа тогтвортой хөгжихөд сэтгэцийн эрүүл мэндэд оруулах хөрөнгө оруулалт зайлшгүй чухал нөлөөтэйг онцлоод боловсролын сэтгэлзүйн ачааг улс орноороо хамтдаа үүрэх ёстойг зөвлөж байлаа. Түүний хэлсэн үгнээс онцолт.



“...Хэт удаан үргэлжилж буй энэ цар тахлын улмаас Сэтгэцийн эрүүл мэндэд анхаарлаа хандуулах нь нэн тэргүүний зорилт болоод байгаа. Аливаа хязгаарлалтын давуу болон сул талуудыг сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөх талаас нь сайтар тооцох шаардлагатай байна.

...Сэтгэцийн эрүүл мэнд нь сайнгүй бол хүмүүс өөрийгөө авч явах, боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, нийгмийн амьдралд оролцох гэх мэт өдөр тутмын ажлаа хийх чадваргүй, эсвэл чадвар дутмаг мэт санагддаг. Тиймээс сэтгэцийн эрүүл мэндэд оруулсан хөрөнгө оруулалт нь улс орон, бүс нутаг, дэлхий даяар тогтвортой хөгжихөд зайлшгүй шаардлагатай юм. Тогтвортой хөгжлийн зорилт (SDG) 3.4-т анх удаа дэлхийн түвшинд сэтгэцийн эрүүл мэндийн ач холбогдлыг онцгойлон гаргаж ирсэн. Улс орнууд оюутан сурагч, багш нарын сэтгэцийн эрүүл мэндэд хөрөнгө оруулалт хийж үүгээрээ тэдний гэр бүлийн сайн сайхан байдалд нь шууд бусаар хөрөнгө оруулахад илүү нухацтай хандаж эхэлсэн байна.

Сургуулийн сэтгэл зүйчид та бүхэн тоглоомыг өөрчлөх хүч мөн бөгөөд бүхэл бүтэн системийн нэг хэсэг юм. Сургуулиуд

Бид тухайн хүнд өөрийнх нь хүсэлтээр сайн дурын үүднээс зөвлөж туслах ёстой. Мөн хувь хүний, үйлчлүүлэгчийнхээ нууцыг чандлан хадгалах үүрэгтэй. Сэтгэл зүйчид хувь хүний хамгийн үнэтэй, нууц, нандин мэдээллүүдтэй ажилладаг. Тиймээс ч сэтгэл зүйчийн төмөр шүүгээнд хуулийн ажилтнууд ч халдах эрх байхгүй. Бид бол эмчийн адил тангараг өргөсөн мэргэжилтнүүд.

Б.ЧИНГҮҮН: "УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ АЖИЛЛАХАД ТҮЛХҮҮ АНХААРНА"

Ерөнхий боловсролын 122-р сургуулийн сэтгэл зүйч:

2020 онд МУИС-ийг сэтгэл зүйч мэргэжлээр төгссөн. Боловсролын сэтгэл зүйч бол практик сэтгэл зүйч. Сэтгэл зүйн тулгамдсан асуудлаас урьдчилан сэргийлж ажиллахад гол анхаарлаа хандуулна гэж төлөвлөж байна. Сургууль, цэцэрлэгт сэтгэл зүйчийн шаардлага, хэрэгцээ маш их байгаа гэж ойлгосон. Нэн тэргүүн би яг энэ цаг үед тухайн нөхцөл байдлыг үнэлж, үнэлгээндээ тулгуурлаж ажлаа төлөвлөнө. Ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж өгсөн бүгдэд баярлалаа.

СУРГУУЛИЙН СЭТГЭЛ ЗҮЙЧДИЙН ӨРӨӨ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ОНЦЛОГТ ТОХИРСОН БУЛАНТАЙ



ТХБ-НЭГ СЭДВЭЭР буландаа “БОЛОВСРОЛЫН ТЭГШ ХАМРАЛТ”-ыг онцолж байна. Боловсрол дахь тэгш хамралт нь нийгэм дэх тэгш хамралтын дэд хэсэг билээ.

“Тэгш хамруулсан, тэгш боломжийг хангасан чанартай боловсрол”-оор хангах болон “бүх нийтийн насан туршидаа суралцахуй”-г хөхүүлэн дэмжих тухай “Тогтвортой хөгжлийн зорилго 4”-ийн үүрэг амлалт нь хөгжлөөс хэнийг ч хоцроохгүйг амласан НҮБ-ын Тогтвортой хөгжлийн төлөвх 2030 хөтөлбөрийн нэг хэсэг юм.”

ЮНЕСКО-ийн тайлангийн илтгэлээс.

ЦАР ТАХЛЫН ҮЕД БОЛОВСРОЛД ҮЛ ХАМРАГДАХ БАЙДАЛ ГҮНЗГИЙРЧ БУЙГ АНХААРУУЛСААР...

ЮНЕСКО-ийн 2020 оны Боловсролын хяналт-шинжилгээний “Тэгш хамралт ба боловсрол” сэдвээр хийсэн тайланд боловсрол эзэмшихэд тулгардаг гол бэрхшээл нь ядуурал гэж тодорхойлсон байдаг. Дээр нь КОВИД19 цар тахлын үед боловсролд үл хамрагдах байдал дэлхийн улс орнуудад улам гүнзгийрч буйг анхааруулсан.



“Тогтвортой хөгжлийн зорилго 2030” хөтөлбөрт тусгагдсан боловсролын зорилтуудад хүрэхээр ажиллаж буй 209 улсын хэрэгжилтийг судлахад ядуурлаас болж 258 сая хүүхэд, залуус боловсролд бүхэлдээ хамрагдахгүй байгааг тогтоожээ. Бага, бага-дунд орлоготой улсуудын 40 хувь нь сургуулиуд түр хаагдсан хугацаанд амьдралын боломж тааруу суралцагчдыг дэмжээгүй гэж тайланд дүгнэсэн байдаг. Мөн боловсролын тэгш хамруулалтад хүрэхэд саад болж буй нэг бэрхшээлийг эцэг, эхчүүдийн ялгаварлан гадуурхсан итгэл үнэмшил гэж тогтоосон юм. Тухайлбал, Германд эцэг эхчүүдийн 15 хувь, Хятадын Хонконгт 59 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бусад хүүхдийн суралцахуйд саад болно гэж сэрэмжилдэг гэжээ.

Бага, дунд орлоготой улсуудын бараг тал нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын талаар хангалттай мэдээлэл цуглуулдаггүй байна. Боловсролын тоо баримт, мэдээллийг ангилан задлах түлхүүр нь өрхийн судалгаа. Гэвч дэлхийн нийт хүн амын 13 хувь оршин суудаг улсуудын 41 хувь нь ийм судалгаа хийгээгүй, эсвэл судалгааны мэдээллээ ил болгоогүй байна. Суралцахуйн талаарх тоон үзүүлэлтүүдийг сургуульд явдаггүй хүмүүсийг харгалзан үзэлгүйгээр сургуулиудаас ихэвчлэн авдаг гэж “Тэгш хамралт ба боловсрол” тайланд өгүүлсэн байдаг юм.

Тайлангаар тэгш хамруулах боловсролын талаарх ойлголтоо өргөжүүлэх, үйлчилгээний гадна үлдэж буй бүлгийнхэнд санхүүжилтийг чиглүүлэх, мэдлэг туршлага, нөөц бололцоогоо хуваалцах, олон нийт, эцэг эхчүүдтэй идэвхтэй хамтран ажиллах, боловсролын салбарын ажиллах хүчнийг бэлтгэж, чадавхжуулж, тэдэнд урам зориг өгч байх гээд 10 зүйл бүхий зөвлөмж гаргасан байдаг.




ХЕЛЕН КЛАРК “БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ БҮХ ЯЛГААГ АРИЛГАХ АЖЛАА ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЁСТОЙ...”

“...Боловсрол дахь тэгш хамруулалт гэдэг нь суралцагч бүр өөрийг нь үнэлж, хүндэтгэж байгааг мэдэрч сургуульдаа хамаатай гэсэн тодорхой мэдрэмж авах явдлыг хангах хэрэг юм. Ялгаварлан гадуурхалт, хэвшмэл ойлголт, хөндийрүүлэлт нь олон хүнийг үл хамрагдахад хүргэж байна. Энэхүү тайлан нь тэгш хамруулалтын үндэс суурь байх ёстой бүх нийтийн хүртээмжийг хангахад гарч буй ялгаа, боловсролын салбар дахь бүх ялгааг арилгах ажлаа үргэлжлүүлэн хийх ёстойг бидэнд сануулж байна.”

БОЛОВСРОЛЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ЗӨВЛӨХ ХОРООНЫ ДАРГА

МАНОС АНТОНИНИС “ЦАР ТАХАЛ НЬ БОЛОВСРОЛЫН ТОГТЛОЦООГОО ДАХИН ЭРГЭЦҮҮЛЭХ БОДИТ БОЛОМЖИЙГ ОЛГОЛОО”



“КОВИД19 цар тахал нь боловсролын тогтолцоогоо дахин эргэцүүлэх бодит боломжийг бидэнд олголоо. Олон талт байдлын үнэ цэнийг ойлгож, талархан хүлээн авдаг дэлхий ертөнц рүү шилжих нь нэг шөнийн дотор бүтэх асуудал биш. Бүх хүүхдийг нэгэн дээвэр дор сургах, сурагчдад хамгийн сайнаараа суралцах орчныг бүрдүүлж өгөх хоёрын хооронд илт зөрүү байгаа нь тодорхой. Гэвч анхаарлаа сайн төвлөрүүлж хичээвэл аливаа зүйлийг өөрөөр хийх бололцоо бидэнд байна гэдгийг КОВИД-19 харуулчихлаа”

БОЛОВСРОЛЫН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭНИЙ ДЭЛХИЙН ТАЙЛАНГИЙН БАГИЙН ЗАХИРАЛ



ОДРИ АЗУЛЭЙ “ТЭГШ ХАМРУУЛСАН БОЛОВСРОЛД ТЭМҮҮЛСЭН ШИЛЖИЛТЭЭС ӨӨР АРГА ЗАМГУЙ”

“...Доромжлол, хуучны хэвшмэл үзэл, ялгаварлан гадуурхалт нь олон сая суралцагчийг анги танхимд суралцах үйл явцаас хөндийрүүлж байна. Өнөөгийн хямрал нь үл хамрах явдлын олон хэлбэрийг цаашид дахин үргэлжлүүлэхээр байна. КОВИД19 цар тахалтай холбогдуулан сургуулиуд хаагдсан нь дэлхийн нийт сурагчдын 90 гаруй хувьд нөлөөлсөн бөгөөд боловсролын салбарын түүхэнд урьд өмнө нь огт үзэгдэж байгаагүй эмх замбараагүй байдалд дэлхий ертөнц ороод байна. Цаг үеийн сорилтуудыг амжилттай даван туулахын тулд улам илүү тэгш хамруулсан боловсрол руу тэмүүлсэн шилжилтээс өөр арга зам үгүй.”

ЮНЕСКО-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Бодлого-хөтөлбөр

ТЭГШ ХАМРУУЛАХ ЗАРЧИМД СУУРИЛСАН “НОГООН ГЭРЭЛ” ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛНЭ

Сурагчид 2020 оны хичээлийн жилд нийт сургалтынхаа 45-47 хувь, 2021 оны хичээлийн жилд 62-68 хувийг зайнаас суралцлаа.

Шинэ төрлийн коронавирусын дэгдэлт дэлхийн улс орнуудад хурдтай тархаж байгаатай холбогдуулан Монгол Улсын онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн хичээл, сургалтын үйл ажиллагааг 2020 оны 01 дүгээр сарын 27-оос түр хааж, цаашид 4 удаагийн шийдвэрээр үргэлжлүүлэн сунгасан.

2020 оны хичээлийн жилд ЕБС-ийн сурагчид 75 өдөр буюу 15 долоо хоног, нийт сургалтын 45-47%-д зайнаас буюу теле хичээлээр тухайн ангийн агуулгыг судалсан байна.

Манай улсад халдварт өвчний тархалт илэрсэнтэй уялдуулан УОК-ын 2020 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 12 дугаар тогтоол, Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2020 оны А/146, А/151 дугаар тушаал, 2021 оны А/165, А/24 дүгээр тушаалуудыг тус тус үндэслэн бүх шатны боловсролын байгууллагын сургалт, үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 11-ээс 2021 оны хичээлийн жилийг дуустал хугацаанд сунгасан.

2021 онд орон нутгийн ЕБС-ийн сурагчдад 100 өдөр буюу 20 долоо хоног, нийт сургалтын 62%, нийслэлийн ЕБС-ийн сурагчдад 110 өдөр буюу 22 долоо хоног, нийт сургалтын 68%-ийг зайнаас суралцлаа.

КОВИД-19 цар тахлын үед буюу өнгөрсөн хоёр жилийн хугацаанд 5 284 теле хичээл бэлтгэн дохионы хэлний орчуулгатайгаар телевизээр зайны сургалт зохион

Судалгаа, арга зүй

ТЭГШ ХАМРУУЛАХ НЬ

“Тэгш хамруулах боловсролын талаар баримтлах бодлого” (UNESCO, 2009) нь тэгш хамруулах хийгээд боловсролын чанар нь нэг зоосны хоёр тал бөгөөд зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бус үндэсний цөөнх, хөдөөгийн, хотын захын, нийгэм, сэтгэлзүйн болон суралцахуйн бэрхшээлтэй бүх насны хүмүүст суралцах тэгш боломж олгох, тэдгээрийн ялгаатай байдалд хандах сөрөг хандлагыг бууруулах үйл явц хэмээн тодорхойлсон. Суралцагчийн ялгаатай байдал, сурах онцлог, хэв маягт нийцсэн, тэдний идэвхтэй оролцоог дэмжсэн тэгш хамруулах сургалтын арга зүйг эзэмших, хэрэглэж хэвшүүлэх шаардлага багш нарын өмнө тавигдаж буй.

Та бүхэнд зарим судлаачдын сургалтын арга зүйн нийтлэлээс хүргэж байна.


байгуулсан. Мөн 104 интерактив хичээл, 2 775 цахим хичээл, 50 цахим контент, 30 радио болон аудио хичээл бэлтгэн econtent.edu.mn бусад цахим сангийн дэмжлэгээр сурагчдад хүргэжээ.

2021 онд ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлэх сургалт, үйл ажиллагааны хүрээ

• Сурагчийн өөрийн удирдлагатай суралцахуйг дэмжиж хөгжүүлнэ. Сурагч өөрийн суралцах үйлийг ойлгох, суралцахуйд сэдэл тэмүүлэлтэй, хариуцлагатай, багштай хамтран суралцахуйн орчныг хувирган өөрчлөхөд оролцдог байна. Үүний тулд бүх сурагчдад зориулсан алхам алхмаар өөрийн удирдлагатай “Бие даан суралцах ажлын дэвтэр” боловсруулж хэрэгжүүлнэ.


• Багш нар явцын үнэлгээнд үндэслэн сурагчийн сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах, суралцахуйг дэмжиж ажиллана.

• Сургууль бүр хосолсон сургалтын арга зүй, орчин, явцын үнэлгээний цахим платформыг хөгжүүлж, багш, сурагч, эцэг эхийн хамтын оролцоог дэмжиж ажиллана.



Үүний тулд 2021-2022 оны хичээлийн жилд сурагчдад нийгэмшил, сэтгэл зүй, эрүүл ахуйн зөвлөмж, дэмжлэг үзүүлэх “Ногоон гэрэл” үйл ажиллагааг хэрэгжүүлэх, сурлагын хоцрогдлыг оношлох, хосолсон сургалтын орчин, арга зүйг төлөвлөж хэрэгжүүлэх, “Бие даан суралцах ажлын дэвтэр”-т ажиллах, сургууль завсардаж болзошгүй сурагчдыг илрүүлж сургуульд эргэн холбох зэрэг судалгаа, арга зүйн ажил хийгдэж эхэллээ.

“НОГООН ГЭРЭЛ” үйл ажиллагааны зорилго, зорилтууд



“Ногоон гэрэл” үйл ажиллагааны менежмент нь тэгш хамруулах боловсролын зарчимд суурилах бөгөөд цар тахлын дараа сургуулийн үйл ажиллагааг дахин нээх, сурагч сургуулийн болон ангийн хамт олонтой нэгдэх үйлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянан шинжлэх, сайжруулахад чиглэгдэнэ. “Ногоон гэрэл” үйл ажиллагаа нь дараах 5 зорилттой хэрэгжинэ.



А.ЭНХТОГТОХ

Боловсролын хүрээлэнгийн Боловсролын хөтөлбөрийн судалгааны секторын эрхлэгч



ТЭГШ ХАМРУУЛАХ СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

Д.МӨНХЖАРГАЛ Боловсрол судлалын доктор, профессор


Сүүлийн жилүүдэд тэгш хамруулах сургалтын арга зүйг дискурсийн онолын үүднээс судлах, суралцахуйг дэмжин хөтлөхөд хэрэглэж байгаа бөгөөд миний бие 2003-2006 онд АНУ-ын бага ангийн сурагчдыг хамруулан явуулсан судалгааны үр дүнд үндэслэн хичээлийн дискурсийн хэв шинжээ хэрхэн өөрчлөх талаар багш нарт зөвлөж буй (Munkhjarval.D, 2006).

Эхний зурагт үзүүлсэн “Санаачилга – Хариу үйлдэл – Үнэлгээ” (Initiation - Response - Evaluation IRE Pattern) гэсэн дискурсийн идэвхгүй хэв шинж анги танхимд түгээмэл ажиглагддаг. Энэхүү дискурсийн хэв шинж нь багш асуултыг өөрөө санаачлах бөгөөд хариулах сурагчаа ч өөрөө сонгодог. Сонгогдсон сурагч хариулсны дараа багш тэрхүү хариултад үнэлгээ өгөөд дискурсийг хаадаг. Энэ тохиолдолд►

►хичээлийн дискурсад багшийн шугам давамгайлж байгаа бөгөөд сурагчийн шугам хараахан нээгдээгүй, дикурсийн байр

суурийг багш дангаар эрхшээж, сурагчдын хүч боломжийг ашиглахгүй, бүх шийдвэрийг дангаараа гаргаж байдаг.


Зураг 1. “Санаачилга – Хариу үйлдэл – Үнэлгээ” дискурсийн хэв шинж



Харин дарах зурагт үзүүлсэн судлаачийн санал болгож буй “Суралцагчийн дуу хоолойг хүлээн зөвшөөрөх” дискурсийн хэв шинж (Revoicing pattern) нь сурагч асуулт болон тайлбарыг санаачлах бөгөөд сурагчид өөрсдөө хариулт өгдөг. Багш сурагчийн дуу хоолойг хүлээн зөвшөөрч сурагчийн хариултыг давтан илэрхийлж болдог. Суралцагчид

хариултыг хэлэлцсэний дараа мэдлэгийг бүтээх зөвшилд хүрдэг. Энэ тохиолдолд хичээлийн дискурсад багшийн шугам давамгайлахгүй харин суралцагчдийн идэвхтэй шугамууд нээгдэж, дикурсийн байр суурийг багш суралцагчид хамтаар эрхшээж, сурагчдын хүч боломжийг ашиглан, бүх шийдвэрийг хэлцэн зөвшилд хүрэх замаар гаргах боломж бүрддэг.

Зураг 2. “Суралцагчийн дуу хоолойг хүлээн зөвшөөрөх” дискурсийн хэв шинж



Боловсролын аль ч шатны багш нар өөрсдийн зааж буй хичээлийн дискурсийн идэвхгүй хэв шинжээ (Зураг 1) ажиглан судалж дискурсийн идэвхтэй хэв

шинжийг (Зураг 2) эрэлхийлэх, хэрэглэж хэвших аваас тэгш хамруулах сургалтын арга зүйд ойртон дөхнө. Жич: Дэлгэрэнгүй илтгэлийг БМДИ-ийн сайтаас үзнэ үү.

АНУ-ААС МЭДЭЭЛЖ БАЙНА

АНУ БОЛОВСРОЛЫН ХОЦРОГДЛЫГ АРИЛГАХ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ

АНУ-ын Конгрессийн дэргэдэх Эрүүл мэндийн байнгын хорооны дэргэдэх Эрүүл мэндийн хэмжил зүйн газрын гүйцэтгэх захирал Б.МӨНХНЯМ мэдээлж байна.



АНУ-д муж болгон өөр өөрийн захиргаа, бодлоготой учраас захиргааных нь боловсролын хэлтэс шийдвэрээ гаргадаг. Ганцхан яамны шийдвэрт захирагддаггүй, тус тусдаа үйл ажиллагаа явуулдаг гэсэн үг. Жишээ нь АНУ-д цар тахал ид дэгдэх үеэр зөвхөн ковидын халдвар ихэссэн мужийн сургуулиуд түр хаагдаж бусад мужийн сургуулиуд хэвийн ажиллаж байсан. Хүүхдүүдээ халдвар авахаас болгоомжилсон эцэг эхчүүд цөөнгүй байсан тул сургуулийн захиргаанаас сургуулийнхаа номын сан, компьютерын өрөө танхимаа бүрэн нээлттэй ажиллуулсан. Ингэснээр гэртээ интернетгүй, номын хүрэлцээ тааруу оюутан, сурагчид хүссэн үедээ шаардлагатай ном, материалаа сургуулиас авах боломжоор хангагдаж байлаа. Ялангуяа хүн ам тархан суурьшсан мужуудад багш нар анги танхимдаа ирсэн сурагчдын зайг бариулж хичээллэж байсан юм.

Өнгөрсөн жил АНУ-ын 50 мужаас 30 орчим нь хичээлээ 1-3 сар хүртэл хааж, 70 хувь нь нээлттэй ажилласан.



Хэдхэн хоногийн өмнө тус улсын Ерөнхийлөгч Жо Байден Ковид19-ын нөхцөл байдалд зориулсан боловсролын тусгай хөтөлбөр гаргаж байгаагаа зарлалаа. Энэ хөтөлбөрийн хүрээнд Америк даяар хүүхдүүдийн түвшинг тогтоож, дараа нь гурван үе шаттай арга хэмжээ авах юм байна. Хоцрогдсон хүүхдүүдийн тоо, судалгааг гаргаж, тэдний хоцрогдлыг арилгах үйл ажиллагааны зардлыг Засгийн газар нь хариуцахаар боллоо.

2022 оны 08 дугаар сар гэхэд сурагчдын хоцрогдлыг арилгана гэж төлөвлөсөн. Мөн хүүхдийн нийгэмшил, хүмүүжлийг анхаарч, энэ чиглэлээр эцэг эх, хүүхдүүдийн дунд судалгаа явуулсан байна.

Судалгаагаар анги танхимд, багштайгаа, бие биетэйгээ харилцаж суралцвал чанартай, үр дүнтэй байна гэсэн дүн гарсан байгаа юм. Эцэг эхчүүд нь “Хөл хорионоос болж хүүхдүүд гэртээ сууснаар нийгэмшилээс хоцорч, хувиа хичээсэн хүн болж өсөж байна. Хүмүүстэй зөв харилцдаг хүн болгохын тулд танхимын хичээлдээ орохыг дэмжинэ” гэж хариулсан тухай танилцуулж байсан. Энэ нь танхимын сургалтын арга барил шилдэг нь хэвээрээ байгааг илтгэж байна.

Хөл хорионы үеийн цахим хичээлийн үр дүнг тодорхойлох зорилгоор АНУ, Япон, Австрали, Канад зэрэг найман улсын багш нараас 1-10 оноогоор үнэлүүлж судалгаа авахад тэд цахим сургалтынхаа үр дүнг дунджаар 4.8 оноогоор үнэлсэн байна. Хөгжлийн хувьд тодорхой түвшинд хүрсэн улс орнууд цахим сургалтын үр дүнгээ 50 хувиар үнэлж байгаа бол Монгол улсын хувьд ямар байгааг хэлэхэд амаргүй болов уу гэж бодож байна.



ЯЛГААТАЙ СУРАЛЦАХУЙН АРГА ЗҮЙ

Ч.ОЮУНБИЛЭГ СУИС-ийн ХУС-ийн ахлах багш, Багш, урлагийн боловсролын тэнхимийн зөвлөх

Хүүхэд бүрийн өвөрмөц онцлог, хэрэгцээ, сонирхлыг таньж, ойлгож, давуу талд нь суурилж ажиллах нь багшийн үүрэг. Иймд хүүхдийн ялгаатай байдлыг (сонирхол, авьяас, мэдлэг чадвар, арга барилын ялгаа) хүлээн зөвшөөрч, бүх хүүхдийг боловсрол эзэмших тэгш боломжоор хангах, ялгаатай нөхцөл байдал (жендэр, нийгмийн гарал, угсаа, амьдралын боломж, ар гэрийн дэмжлэг, хэл соёл, хөгжлийн ялгаа, суралцах чадварын түвшнээс хамаарсан), ялгаатай хэрэгцээнд нь нийцсэн сургалтын арга зүйг нэвтрүүлэх шаардлага тулгараад байна.

Ялгаатай суралцахуй бол сурагч бүрт зориулсан ганцаарчилсан хөтөлбөр биш. Харин нэг ангид байгаа түвшний ялгаатай, өөр өөр сонирхолтой, сурах арга барилын ялгаатай хүүхдүүдийг ойролцоо шинжүүдээр нь бүлэглээд, хөтөлбөрөө уян хатан ялгаатай арга, хэлбэрээр сурагч бүрт хүргэх юм. Гол нь хүүхэд бүрийн сурах бэлэн байдал, сонирхол, мэдээллийг хүлээж авч боловсруулдаг арга барил, мэдлэг чадварын түвшинг оношил, түүнд нь тохирсон ялгаатай аргаар ажилла, хүрэх үр дүндээ баримжаалж хэнд ямар ачааллыг, ямар хэмжээгээр өгч ямар хурдаар ажиллуулахыг тооц, сурагчдад

сонголт хийх боломж олго, сурагч бүрийн хүрсэн түвшинд нийцсэн даалгавар сорилтыг тавь. Энэ нь суралцагчийн мэдлэг чадварын өсөлтийг нэмэгдүүлэх ач холбогдолтой гэж үзэж байна. Эндээс л сайн үр дүнг хүлээх боломж бүрдэнэ.

Жишээ нь: Сурагчдыг тодорхой шинж чанараар нь бүлэглээд, эсвэл өөрт хамгийн тохиромжтой санагдсан ажилбарыг сонгох боломжийг нь олговол тэд өөрсдийн чадварын түвшин, сонирхол болон сурах арга барилдаа нийцүүлж шинэ мэдлэг мэдээллийг боловсруулж чадна.

Зарим сурагчид багш нүүр тулан харилцахад илүү үр дүн гаргадаг бол зарим нь бие даан сурах чадвартай байдаг. Өөрөөр хэлбэл тэд багшаас ижил хэмжээний тусламж шаардахгүйгээр багаар хамтрах эсвэл ганцаарчлан ажиллах чадвартай байдаг. Тайлбарыг сайн сонсож, асуулт асууж, тэмдэглэл сайн хөтөлдөг хүүхэд байхад зарим нь өгөгдсөн материалыг харж бодлоо илтгэдэг, илэрхийллээ ч харах өнцгөөс гүйцэтгэнэ. Зарим нь бүр өөрийн гараар хийж оролдож сурдаг.

Хамгийн гол нь сурагчдын онцлогийг тогтоож тохирох аргуудыг оновчтой сонгон ашигласнаар мэдлэг бүтээх, шинэ чадвар эзэмших, дадлагажих үйл ажиллагаа болох бөгөөд үр дүн ч сайжирна.

Бид өмнө нь гарааны үнэлгээ хийдэг байсан. Гэхдээ зөвхөн түвшин тогтоодог. Харин одоо бол ялгаатай суралцахуй буюу сурагч бүрийн хэрэгцээ, сонирхол, сурах бэлэн байдал, суралцах чадвар, арга барилын онцлогийг тооцож ажиллаа, өөрөөр хэлбэл хүүхдийн ялгаатай байдлаас үл хамааран боловсролд тэгш хамруулж үйлчилгээгээ чанартай үзүүлье л гэсэн санаа.



“ТХБ-ЗОЧИН”-оор БШУЯ-ны газрын дарга Т.Ням-Очирыг урьж “тэгш хамран сургалт-чанартай боловсрол” сэдвийн хүрээнд ярилцлаа.

Тэгш хамруулсан, тэгш боломжийг бий болгосон чанартай боловсролыг олгох, насан туршид суралцах боломжоор хангах нь дэлхийн нийтийн тэмүүлж буй ТХЗ-ын нэг зорилт, амлалт. Энэ зорилтод чиглэсэн МУ-ын Засгийн газрын, салбарын яамны хийж хэрэгжүүлж байгаа гол бодлого, үйл ажиллагааг тодотговол?

Боловсролыг бүх нийтийн эрх болгох, энэ эрхийг хүн бүрийн хувьд бодитоор хэрэгжүүлэх нь чухал. Олон төрлийн сорилт, бэрхшээлүүд нь боловсрол эзэмших боломж тэгш бус байсаар байгааг та бидэнд сануулж байна. Таван хүүхэд тутмын нэг нь КОВИД-19 цар тахал гарахаас өмнө хүртэл боловсролын үйлчилгээнд огт хамрагддаггүй байсан тухай НҮБ-ын тайланд дурдсан байна. Цаашлаад гадуурхал, хуучны хэвшмэл үзэл, хандлага нь олон мянган хүүхдээс тэгш боломжийг хулгайлж байгааг бид ухаарах ёстой.

КОВИД-19 цар тахал нь нийгэм дэх тэгш бус байдлыг улам бүр ил тод болгож байна. Боловсролын салбарыг бэхжүүлэхийн тулд боловсролын гаднах тэгш бус байдалд илүү анхаарах цаг нэгэнт болжээ. Мөн дижитал хуваагдал бодит асуудал боллоо.

СУРАЛЦАГЧ БҮРТ ӨӨРИЙГ НЬ ҮНЭЛЖ, ХҮНДЭТГЭЖ БАЙГААГ МЭДЭРЧ СУРГУУЛЬДАА ХАМААТАЙ ГЭСЭН ТОДОРХОЙ МЭДРЭМЖ ӨГӨХ НЬ ЧУХАЛ

БШУЯ-наас Боловсролын ерөнхий хууль, түүнийг дагалдан гарах хуулийн төслүүдийг УИХ-ын өнгөрсөн хаврын чуулганд өргөн барьсан. Боловсролын зорилго, зорилтоосоо эхлэн өөрчлөхийг зорьж байна. Суралцагч бүрт өөрийг нь үнэлж, хүндэтгэж байгааг мэдэрч сургуульдаа хамаатай гэсэн тодорхой мэдрэмж өгөх нь чухал. Иймийн тулд сургахаас суралцахуй гэсэн концепцыг хуульд шингээж өгч байгаа. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд тэгш хамран сургах бие даасан бүлгийг тусгаж өгсөн. Насан туршдаа суралцахуйн асуудлыг хуульд шинээр томьёолсон. Албан болон албан бус боловсролоос гадуур гэр бүл, ажлын байр, хүрээлэн буй орчноос бие даан суралцах буюу “амьдралын орчинд суралцах” үйл ажиллагааг хуульд тусгасан.

Хууль, эрх зүйн хувьд шинэчлэлүүдийг хийх хэдий ч тэрхүү туйлын зорилгод хүрэхэд олон саад бэрхшээл тулгарна. Хөгжлийн хүнд бэрхшээлтэй сурагчид болон сурагч нэг бүрийн хэрэгцээнд нийцсэн тогтолцоо руу шилжих нь хүн бүрийн

Т.НЯМ-ОЧИР “СУРАЛЦАГЧДЫН ХОЦРОГДЛЫГ НӨХӨЖ, АРИЛГАХ ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЭЛСЭН”

оролцоог шаардана. Өөрчлөлтийг хэрхэн хийх вэ, хөгжсөн улс орнуудын тусгаарлалт дээр суурилсан тогтолцоог эргэн харж өөрчлөх үү, эсвэл тэгш хамруулсан тогтолцоог эхнээс нь цоо шинээр бүрдүүлэх үү гээд олон талаас нь судалж, тогтвортой-сайн шийдлийг олох нь бидний үүрэг.

ХҮҮХДҮҮДЭД СЭТГЭЛИЙН ТҮГШҮҮР, ХЯМРАЛЫН ТҮВШИН ӨНДӨР БАЙГАА НЬ СУДАЛГААГААР ТОГТООГДСОН

Ковидоос үүссэн цар тахлын энэ нөхцөл байдал, хөл хорио МУ-ын боловсролын салбарт, тэр дундаа ерөнхий боловсролын түвшинд ямар хүнд нөхцөл байдлыг бий болгоод байна?

Цар тахлын үеийн тодорхойгүй байдал, өсвөр насны хүүхдүүд үе тэнгийнхэнтэйгээ харилцах, уулзах боломжгүй болох, хэвийн үеийн дэглэм өөрчлөгдөх, эцэг эхийн гэрээсээ ажиллах эсвэл ажлын байраа алдахтай холбоотой стресс зэрэг нь хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх гэх зэргээр олон асуудал, сөрөг үр дагавар бий болсон.

Олон хүүхдүүд хоол, шим тэжээлийн дутагдалд орж, шаардлагатай шим тэжээлээ авч чадахгүйд хүрсэн. Тэгэхээр сургуулийн хоол ямар чухал болох нь харагдаж байна. Мэдээж, хүүхдүүдэд сэтгэлийн түгшүүр, хямралын түвшин өндөр байгаа нь судалгаагаар тогтоогдсон.

Танхимын сургалтыг юугаар ч орлуулж, нөхөх боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Ялангуяа сургуулийн өмнөх, бага боловсролын түвшинд. Хэдий зайн сургалтын боломжит олон хувилбарыг нэвтрүүлж, хэрэгжүүлж байгаа ч дэд бүтэц, тоног төхөөрөмж, хүний нөөц гээд олон зүйлд бид бэлэн биш байлаа.

Сургууль бүрт хос сургалтын орчныг бүрдүүлж, багш бүр байгаль цаг уур, цар тахлын гээд ямар ч үед хичээл сургалтыг удирдан зохион байгуулах хосолсон сургалтын арга зүйтэй болж хөгжин, хүүхэд, эцэг эхчүүд өөрийн удирдлагатай, бие даан суралцах сургалтын шинэ арга хэлбэрийг нутагшуулах нь бидний алсын хараа байна.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧДЫН ХОЦРОГДЛЫГ НӨХӨХ, АРИЛГАХ ГУРВАН ЖИЛИЙН /2021-2023/ ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН. ЗАСГИЙН ГАЗАР ХЭЛЭЛЦЭН БАТАЛСАН

АНУ зэрэг улс оронд цар тахлаас үүдсэн боловсролын хоцрогдлыг арилгахын тулд нарийн судалгаа явуулж, тусгай хөтөлбөр гарган хэрэгжүүлж байна. Манай улс энэ чиглэлээр ямар ажлуудыг өрнүүлж байна?

БШУЯ-наас ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах гурван жилийн /2021-2023/ цогц төлөвлөгөөг боловсруулан Монгол Улсын Засгийн газарт танилцуулан, баталсан.

Хоцрогдол нөхөх гэдэг нь нэг удаагийн арга хэмжээ бус системтэйгээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа байна. Цаашлаад хүүхэд нэг бүрт тохирсон сургалтын арга зүйг хөгжүүлэх, хүүхдийн ахицаар нь үнэлж, дэмжих боловсролын шинэчлэлийн нэг хэсэг болж, нутагших ёстой гэж үзэж байна.

Онцгой байдлын үеийн теле хичээл, түүний үр дүн, тохиромжтой байдлын судалгаа, Хүүхдийн нийгэм-сэтгэл зүйн асуудал, эрсдэлийг илрүүлэх судалгаа, нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа /зайн сургалт/-г зохион байгуулж, үр дүнг бодлого, шийдвэрүүдэд тусган ажиллаж байна.

Энэ хичээлийн жилийн эхэнд багш, суралцагч, эцэг эхийн нийгэм, сэтгэл зүйн асуудалд чиглэсэн “Ногоон гэрэл” үйл ажиллагааны удирдамжийг баталж хэрэгжүүлж байна. Үндэсний түвшинд хүүхдүүдийнхээ гарааны оношилгоог хийнэ. Хоцрогдол арилгахад зориулсан “Дасгал ажлын дэвтэр”-ийг боловсруулан ашиглаж эхэллээ. Аймаг, дүүрэг тус бүрт багш нарын бүлгүүд байгуулагдан хамтран ажиллаж байгаа гээд батлагдсан цогц төлөвлөгөөний дагуу хоцрогдол арилгах үйл ажиллагааг зохион байгуулж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД ӨӨРИЙН ХАМРАН СУРГАХ ТОЙРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД ЭЛСЭН СУРАЛЦАХ НЬ НЭЭЛТТЭЙ

Манайд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, малчин, хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн дунд боловсролын хоцрогдол гарч байгааг зарим иргэд, судлаачид сануулж, шүүмжилдэг. Энэ нь заримыг нь ялгаатай байдлаар авч үзэж нийгмээс тусгаарладагтай ч холбоотой гэж үздэг. Үүн дээр ямар бодлого барьж, хэрхэн ажиллаж байна вэ?

Ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журмыг баталсан. Үүний дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд өөрийн хамран сургах тойргийн ерөнхий боловсролын сургуульд элсэн суралцах нь нээлттэй болсон.

Өөрөөр хэлбэл, ерөнхий боловсролын сургууль нь хүүхдийн ялгаатай байдал, хэрэгцээг хүндэтгэсэн уян хатан сургалтын бодлого, хөтөлбөр боловсруулах, хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сургалтын орчин, тохирох хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, мэдээллийн технологийг сургалтад ашиглах, хүүхдийг учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин бүрдсэн.

Ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах боловсролыг дэмжих дэмжлэгийн баг ажиллаж байна.

Мөн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам хэрэгжиж байна. Амьдралын нөхцөл боломжоос шалтгаалж эрсдэлд орсон хүүхдүүдэд боловсролын үйлчилгээг тасралтгүй хүргэх, эдгээр хүүхдүүдийн судалгаа, мэдээллийг сургууль, хороо, цагдаагийн байгууллагууд хамтран ажиллаж бүрдүүлэх, солилцох гэх зэргээр дэмжин ажиллаж байна.

Малчин өрхийн 6 настай хүүхдийг эцэг эх нь хүсэлт гаргавал 7 настай элсэх боломж мөн нээлттэй.

Чанартай боловсрол нь мэдээж төсөв санхүүтэй шууд холбоотой. Энэ хичээлийн жилд урсгал зардал болоод хөрөнгө оруулалт өнгөрсөн 2019, 20 оныхоос хэрхэн өөрчлөгдсөн бол?

Боловсролын салбарт хийх гэж зорьж буй шинэчлэлийн хамгийн гол зүйл нь төсөв санхүүгийн асуудал. Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын аргачлалыг өөрчилж байж цаашид боловсролд зарцуулж буй нэг төгрөг бүрийн үр дүнг тооцдог болох нь чухал.

Боловсролын салбарт улсын төсвөөс зарцуулж буй төсөв буурахгүй байгаа хэдий ч өсөн нэмэгдэж буй хэрэгцээгээ хангахуйц хэмжээтэй төсвийн төлөвлөлт хийгдэж буй эсэхийг эргэж харах ёстой.

2016-2020 онд боловсролын салбарт хамгийн их хөрөнгө оруулалт хийгдсэн. Энэ хэрээрээ хүртээмж өссөн.

НЭН ТЭРГҮҮНД ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫГ ТАСРАЛТГҮЙ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ БЭЛЭН БАЙДЛЫГ БҮХ ТҮВШИНД ХАНГАХ НЬ ЧУХАЛ БАЙНА

“Тэгш хамруулсан, тэгш боломжийг хангасан чанартай боловсрол олгох зорилт нь дан ганц төрийн, ганц салбарын ажил биш гэдгийг хаа хаанаа ярьж эхэлсэн. Тэгвэл олон нийт, эцэг эх ямар үүрэгтэй оролцож, хэрхэн хамтрах ёстой юм бол?

Нийгмийн бүх гишүүд өөрийн нийгмийг хөгжүүлэхэд тэгш оролцож, түүнийхээ үр шимийг хүртэж сайхан амьдрах, эрүүл орчинд төрөх, сайн боловсрол эзэмших ёстой. Энэ бол тогтвортой хөгжлийн үндсэн зарчим.

Иргэн бүрийн хандлагыг өөрчлөх нь нэн тэргүүний алхам байх болов уу. Гэхдээ хүчээр төлөвлөж оролцуулдаг бус өдөр тутмын үйл ажиллагаа, үйлдлээрээ оролцдог соёлыг нутагшуулах нь чухал.

Энэ хичээлийн жилийн хамгийн гол зорилгыг тодорхойлбол?

Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах нь энэ хичээлийн жилийн зорилго юм.

Нэн тэргүүнд хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг бүх түвшинд хангах нь чухал байна. Дижитал технологийг хичээл, сургалтын үйл ажиллагааны үндсэн хэрэгсэл болгон хөгжүүлэх нь бидний хамгийн гол сонголт боллоо.

Цаашлаад хүүхдийг айдас түгшүүр, сэтгэл зовнил, стрессгүйгээр суралцах, хөгжихөд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна. Суралцагчийн бие даан ажиллах үйлийг дэмжсэн дасгал, даалгаврын сан бүрдүүлж үр дүнтэй ашиглах нь зүйтэй.

Эцэст нь багшийн болон сургалтын орчны байгаа нөөцдөө тулгуурлан хичээл, сургалтын үйл ажиллагааны чанар, үр ашгийг сайжруулахыг зөвлөж байна.

Баярлалаа.

МЭНДЧИЛГЭЭ



Дэлхий нийтийг хамарсан COVID-19 цар тахал бидний амьдралын чанар, ажлын хэв шинжийг өөрчилж, хүн төрөлхтөн бид нэг саванд амьдарч цаашид тогтвортой ирээдүйг бүтээх нь чухал гэдгийг бидэнд ойлгуулж, цаашид тодорхойгүй шинэ нөхцөл байдалд амьдарч ажиллах боллоо.

Хүн төрөлхтний хөгжил, хүн амын өсөлт, техник технологийн хурдацтай дэвшил, байгаль орчин уур амьсгалын өөрчлөлт, хүмүүсийн ахуй амьдралд шинэ сорилтыг авчирч байна.

Иймд нийгэм, эдийн засгаа тогтвортой хөгжүүлж, байгаль эх дэлхийнхээ тэнцвэрт байдлыг хангахад хүн төрөлхтөн нийтээрээ анхаарч, тогтвортой амьдралын гол хэрэгсэл, ирээдүйг чиглүүлэгч нь БОЛОВСРОЛ мөн гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрч 2017 онд ЮНЕСКО-оос “Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол” гэсэн баримт бичгийг гаргасан. Энэ баримт бичигт дэлхийн хүн бүрийг суралцагч гэж үзэж, ТХ-ын зорилго зорилтуудыг хангахад чиглэсэн суралцахуйн зорилтууд, агуулгын сэдвүүд арга, хандлага, арга техникийг тодорхойлсон.

Монгол Улс, Монголын боловсролын салбар нь Тогтвортой хөгжил, Тогтвортой хөгжлийн боловсролын түүхэн хөгжлийн үе шат бүрд дэлхий нийтийн шинэ санаачлага, үйл хэргийг ажиглаж, тэдгээрийг хэрэгжүүлэхийн төлөө ажиллаж ирсэн юм.

Швейцарын хөгжлийн агентлагийн шууд дэмжлэгтэйгээр “Тогтвортой хөгжлийн боловсрол-1” төсөл амжилттай хэрэгжсэн.


НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилго 2030” хөтөлбөрийн хүрээнд Монгол улс “Тогтвортой хөгжлийн боловсрол” үндэсний хөтөлбөрийг баталж, урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-д ногоон хөгжлийн бодлогоо суулгаж, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үндсэн дээр боловсролын асуудлыг авч үзэн “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийг хэрэгжүүлж эхэлсэн билээ.

*Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн захирал
Ж.БОЛОРМАА*

“НОГООН ОФФИС”-ИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

Тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжин хамтран ажилладаг байгууллагын хувьд цаашид “Ногоон оффис” болохын төлөө цаасгүй технологи болох үүлэн технологийг сургалтын, албан үйл ажиллагаандаа байнга ашиглаж цахим шилжилт хийгээд байна. Үүнд:

- Байгууллагын удирдлага, алба, хэлтэс хоорондоо Gmail болон Google Drive, мөн түүний дагалдах апплейкшнуудыг байнга хэрэглэж заншсан. Ингэснээр албан бичиг баримт боловсруулах явцад гардаг цаас ноороглох, хэвлэх шаардлагагүй болсон.
- Мөн Google Meet, Zoom, Teams ашиглан шууд видео холболтоор семинар болон хурал, уулзалтуудыг зохион байгуулдаг.
- Сургалт үйл ажиллагаандаа www.esurgalt.itpd.mn LMS платформыг 2014 оноос хойш тасралтгүй 7 жилийн турш тогтмол ашиглаж, цахим, танхим хосолсон сургалтыг хэрэгжүүлээд байна.
- 2020-2021 онд цар тахлын нөхцөл байдлаас үүдэн нийт ЕБС, СӨБ-ын цэцэрлэгийн багш, ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх үндсэн, төрөлжсөн, захиалгат, сонголтот сургалтуудыг 100% цахим хэлбэрт шилжүүлэн ажиллаж байна.
- Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын 17 судлагдахууны гарын авлагыг цахим хэлбэрээр бэлтгэн сургалтын платформ дээрээ байршуулан сургалтаа зохион байгуулж, сургалтын батламжийг <http://batlamj2021.itpd.mn> сайтаар дамжуулан олгож байна.
- “Хичээлийн шинэ жил” эхлэхийн өмнөх ЕБС, цэцэрлэгийн багш нарт зохион байгуулдаг төрөлжсөн сургалтыг цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан цахим хэлбэрт шилжүүлэн



39200 шахам багшийг хамрууллаа. Тухайлбал: 2021 оны 8-р сард “Сурагчдын хоцрогдлыг нөхөх, арилгахад дэмжлэг үзүүлэх арга зүй” сургалтыг орон даяар анх удаа цахим хэлбэрээр ZOOM, GMEET платформ ашиглан зохион байгуулахад 17 судлагдахууны чиглэлээр шууд видео холболтын танхимуудад 8 740 гаруй багш хамрагдлаа. Тэдгээр цахим танхимын үйл ажиллагааг OBS studio болон facebook Live орчинд дахин дамжуулалт /Live/ хийж 30,436 үзсэн буюу сургалтад нийт 39 177 багш хамрагдсан байна.



ЦӨӨН ӨГҮҮЛБЭРЭЭР


ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН БОЛОВСРОЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ҮЛГЭР ЖИШЭЭЧ БАЙГУУЛЛАГА БОЛНО



Байгууллагын стратеги төлөвлөгөө, 2021 оны жилийн төлөвлөгөө, дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр зэрэг баримт бичигт жендэрийн төлөв байдлын дүн шинжилгээ хийж, шинжилгээний үр дүнд үндэслэн байгууллагынхаа хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт орууллаа.

Цаашид ил ба далд хөтөлбөрөөр дамжуулан жендэрийн тэгш байдлын боловсролыг хөгжүүлэхэд үлгэр жишээч байгууллага болох зорилт дэвшүүлэхээр ажиллаж байна.

ӨДӨРТ 1000 ГАРУЙ ОРОЛЦОГЧИДТОЙ СУРГАЛТ



“Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага” дунд шатны сургалтын агуулга, хөтөлбөр /дэд модуль/ боловсруулж, сургалт зохион байгуулах, сургуулийн сургагч багш бэлтгэх ажлыг Тогтвортой хөгжлийн боловсрол-II төсөлтэй хамтран зохион байгууллаа. Ерөнхий боловсролын 30 сургуулийн 1658 удирдлага, багш, ажилтны төлөөлөл хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдлаа. Сургалтад шууд холболтоор өдөрт 1082, 1 цэгээс 499 оролцогч хамрагдаж байсан юм. Одоо II шатны сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажилдаа ороод байна.

БАГШ ХӨГЖЛИЙН ОРДОН СААРАЛ УСАА ЦЭВЭРШҮҮЛЭН АШИГЛАЖ БАЙНА



Багшийн хөгжлийн ордон нь Сэлбэ голтой ойрхон учраас зоорийн давхрын ханаар хөрсний ус нэвчиж орж ирдэг байсан юм. Энэ нөхцөл байдалд тулгуурлан хөрсний усыг ариун цэврийн өрөөний суултуурын ус болгон ашиглахаар төлөвлөж, 2016 онд хөрсний усыг цэвэршуулж ашиглах технологийг Монголдоо анх удаа нэвтрүүлэх ажлын эхлэлийг тавьсан.



Анх 20 тн ус нөөцөлдөг хоёр савтай байсан бол 2019 онд Нийслэлийн захирагчийн ажлын албанаас орчин тойрны ногоон байгууламжийг услах зорилгоор гадна талбайд 50 тн ус нөөцлөх савыг нэмж байршуулсан. Өнөөдөр Багшийн хөгжлийн ордон нөөцөлсөн саарал усаа ариун цэврийн өрөөнүүдийн суултуурын усанд ашиглаж, сард ойролцоогоор 50м.куб ус хэмнэж байна.

Н.МӨНХБАЯР “МИНИЙ АМАРДАГ ГАЗАР БОЛ МАНАЙ БЯЦХАН ХҮЛЭМЖ”

*/Тогтвортой, урт удаан хугацаанд үргэлжлэх
бүхэн энгийн байдаг./*

*Тогтвортой хөгжлийн зан үйлийг амьдралдаа хэрэгжүүлж
буй БМДИ-ийн Суралцагчийн хөгжлийн албаны дарга
Н.Мөнхбаяртай уншигчаа уулзуулъя.*

-Тогтвортой хөгжлийн боловсролыг амьдрал ахуйдаа хэрэгжүүлж эхэлсэн таны туршлагаас ярилцлагаа эхэлье.

2015 оноос манай гэр бүл зуслангийнхаа газрын налуу хэсгийг тэгшилж, элс шороог нь шигшиж зүлэгжүүлээд, хашаагаа тойруулан цөөн тооны мод, бут суулгасан. Орой ажлаа тараад мод зүлгээ услахаар зуслан руугаа явах дуртай болж эхэлсэн.



Амралтын өдрөөр зэрлэгийг нь түүнэ, усална, бордоно. Зэрлэг зулгаахдаа намайг үндсийг нь үлдээгээд байна гээд манай гэр бүлийн хүн бахь бариулаад ингэж зулгаа гээд зааж өгч

байлаа. Бид чинь нарс, гацуураа ч ялгахгүй л ногоон хөгжил, экологийн боловсрол ярьж байгаа хүмүүс байна гэдгээ мэдэрсэн л дээ. Өөрийн гараар тарьж ургуулсан мод бутаа нахиаалад цэцэглээд эхлэхээр өөрийн эрхгүй зуслан руугаа ойр ойрхон тэмүүлдэг болсон. Модтойгоо ярина, цэцэглэснийг харж баясна нарс, гацуураа шарлахаар гуниглана, өт хорхой идэхээр бүүр сэтгэл хачин болно. Энэ бүгдийг хийхэд их ажлын алжаал тайлагдаж, ер бусын амралт болоод байгааг мэдэрсэн. Бид чинь бичиг цаасны ажил ихтэй, компьютерийн ард удаан суудаг, их хотын бужигнасан амьдралтай хүмүүсийн нэг.

-Болдог бол өөрийн гэсэн газартай иргэд бүгд хашаандаа мод бут, хүнсний ногоогоо тарьдаг бол хотын тоосжилт багасна гэж бодогддог.

Тийм шүү. Би гэдэг хүн ингээд л байгаль гэдэг насан туршийн найзтай болсон доо. Ажлаасаа ирээд мод бутаа хараад тойроод явахад л амралт болдог. 2019 онд хүлэмжтэй болж өргөст хэмх тариалж үзлээ. Яг л хүүхэд шиг арчилгаатай. Агаар, усыг нь тохируулна, бордоно, тордоно. Хэд хоног ирээгүй үедээ яасан бол, хэр томорсон бол, шарлаж хатчихаагүй байгаа гэж санаа зовнино. Хашаагаар орж ирээд л хүлэмж рүүгээ ордог доо. Одоо манай хашаанд нарс, гацуур, чацаргана, үхрийн нүд, монос, голт бор, шар хуас нийлсэн 1000 шахам мод, бут ургаж байна.

Өнгөрсөн жилээс мандлын цэцэг ургуулж байгаа. Өнгө алаглаад ирэхээр баяр баясал эрхгүй төрнө. Хүн байгалийн амьтан гээд ярьдаг учир утгыг ойлгож байгаа шүү. Энэ ковидын цар тахлын үед улам бүр мэдрүүлж байна.

-Ковидын халдвартай холбоотой хүмүүсийн амьдралын хэв маяг эрхгүй өөрчлөгдөж байна. Таны хувьд ямар өөрчлөлт мэдрэгдэж байна?


Ковидын нөхцөл байдал хүмүүсийн амьдралын хэв маяг, асуудалд хандах хандлага, шийдвэр гаргалтад шууд нөлөөлсөн. Үүнийг бид тогтвортой хөгжлийн цогц чадамжтай холбож ойлгох хэрэгтэй юм болов уу.



Аливаа асуудалд хандах чадамж, аливаа шийдвэр гаргахад баримтлах чадамж, аливаа үйлдлийг хэрэгжүүлэх чадамж нь сэтгэлгээний шинэ арга барил, шинэ ёс зүй, менежментийн ур ухааныг биднээс шаардаж байна.

Том үр дүнд хүрэхийн тулд богино хугацааны өөрчлөлт, үйлдлээс эхлэх хэрэгтэй гэж би боддог. Энэ үйлдлийн эхлэл бол бидний амьдралын энгийн хэрэглээ, зөв дадал хэвшил. Ус цахилгаанаа хэмнэх, байгальд ээлтэй байх, амьтныг хайрлах, настныг асрах, ажилдаа хариуцлагатай, харилцааны соёлтой байх гэх зэрэг өдөр тутмын үйлүүд юм.

ӨӨРЧЛӨЛТИЙН ТАВАН ТҮВШИН



Хувь хүний мэдлэг, хандлага, зан үйл бол богино хугацаанд хялбархан өөрчлөгдөж болдог. Гагцхүү чин сэтгэлээсээ л хичээх хэрэгтэй. Харин байгууллагын, нийгмийн өөрчлөлт бол урт хугацаа шаарддаг. Тогтвортой хөгжлийн төлөөх хувь хүн бүрийн өөрчлөлт, хичээл зүтгэл нь байгууллагын, нийгмийн өөрчлөлтийг авчирдаг. Өөрчлөлтийн таван түвшний дараах зураглалаас та өөрчлөгдөхийг хүссэн зүйлээ хайж олоорой. Юу хайж байгаагаа мэддэг хүн олдог юм шүү гэж хэлмээр байна. Тогтвортой, урт удаан хугацаанд үргэлжлэх бүхэн энгийн л зүйл байдаг гэж боддог.

-Ярилцсан танд баярлалаа.

ОРХОН АЙМГИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР МЭДЭЭЛЖ БАЙНА


Орхон аймгийн Боловсрол, соёл урлагийн газар 2013 оноос эхлэн тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусгасан эх дэлхийгээ хайрлах, зөв харьцах, хичээлийн онолын мэдлэгийг хэрэглээнд нь судлах, багаар ажиллах чадварыг хөгжүүлэх, хүүхдийн сонирхол авьяасыг нээн илрүүлэх зорилгоор тодорхой ажлуудыг байгууллагуудтай хамтран тогтмол зохион байгуулж ирлээ.

Сургуулийн хөгжлийн менежментийн хөтөлбөрт “Тогтвортой хөгжлийн бодлогод нийцсэн эрүүл аюулгүй эрсдэлгүй эко орчин бүрдүүлнэ” зорилт дэвшүүлж сургуулийн “Эко клуб”, “Энержи”, “Усны элч” клубийн багш, сурагчид хамтран хэд хэдэн ажлыг хийж гүйцэтгэлээ. Тухайлбал ариун цэврийн өрөөний ашиглалтад хуваарийн дагуу хяналт тавин, цаас, савангаар хангах, зөвлөмж байрлуулах, хаягжуулах, сургууль, анги танхимынхаа ус, цахилгааны хэрэглээ алдагдал, хог хаягдлын өнөөгийн байдалд улирал тутам үнэлгээ дүгнэлт өгч, засаж сайжрууллаа.



“Эко булан” аар дамжуулан сурагчдад ус уухын ач тус, зориулалтын усны савны сонголт, зөв хэрэглээ, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага, усаа хэмнэх талаар мэдлэг ойлголтыг өгч, дадал хэвшил болгон ажиллаж байна.

Олон улсын “Эко сургууль” хөтөлбөр, “ТХБ-II” төслийн хүрээнд анги танхим, сургууль орчноо тохижуулах, нүүрстөрөгчийн ул мөрийг бууруулахад сурагчдын бодит оролцоог нэмэгдүүлж, ухаалаг хэрэглээ, зөв дадал, хандлага төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Эко сургууль-Ногоон ирээдүй” аяныг бүх анги, бүлгийн дунд 14 хоногийн хугацаанд зохион байгууллаа.



“ДЭЛХИЙН ТОМ ХИЧЭЭЛ”-ИЙН ШИЛДЭГТ ШАЛГАРЛАА

“ТХБ-II” төслөөс хамтран зохион байгуулсан. “Дэлхийн том хичээл-Тогтвортой хөгжлийн боловсрол” үндэсний хэлэлцүүлэгт тус аймаг сургуулийн өмнөх боловсрол-3, бага боловсрол-4, суурь боловсрол-3, бүрэн дунд боловсрол-4 нийт 14 хичээлээр оролцсоноос улсын хэмжээнд 4 шилдэг хичээл шалгарч, Esurgalt.itpd.mn сайтад байршиж, “Дэлхийн том хичээл”-ийн санд бүртгүүлэх боломжтой боллоо.



СУРАГЧ, ЭЦЭГ ЭХЧҮҮДТЭЙГЭЭ ХАМТРАН 100 000 МОД ТАРИНА

“Нэг зуун мянгаас дээш мод” “Ногоон-Эрдэнэт” төсөл хөтөлбөрийн хүрээнд Орхон аймгийн боловсрол, соёл, урлагийн 76 байгууллагийн 34 000 орчим сурагч, эцэг эх, багш ажиллагсад энэ оны эхний хагас жилд 54 000 гаруй мод тарилаа. 2021 онд нийт 100 000 ширхэг мод тарихаар 76 ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.



ӨРГӨӨНИЙХӨӨ ДЭЭВЭР ТУУРГЫГ БАГШ, СУРАГЧИД ХИЙЛЭЭ

Орхон аймгийн ерөнхий боловсролын Баян-Өндөр сумын 4 дүгээр сургууль ТХБ-II төслийн хүрээнд үндэсний онцлог, өв соёл, уламжлал зан заншил, эх түүхээ мэдэх, өвлөх, хамгаалах, хөгжүүлэх, эрхэмлэн дээдэлдэг дэлхийн монгол иргэнийг төлөвшүүлэх бодит орчин бүрдүүлэх зорилгоор өв уламжлал, түүх, соёлын өргөө байгууллаа. Өргөөгөө эцэг эх, багш ажиллагсад, олон нийтийн дунд өрнүүлсэн “Өв уламжлал, түүх соёлын өргөөг хамтдаа бүтээцгээе” сайн дурын хандивын аяны хүрээнд тоглоом наадгай, морин хуур, монгол гэрийн хэрэгсэл зэрэг 12 нэр төрлийн эд хэрэгслээр чимж тохижуулжээ.

Харин гэрийн дээвэр туурга, ширдэг зэргийг сурагч, багш нар дизайн технологийн хичээлээрээ хамтран хийсэн байна. Ёс заншлын өргөө 4 дүгээр сургуулийн 3100 гаруй сурагчдаас гадна ойролцоох цэцэрлэг, байгууллага гээд 50 гаруй аж ахуйн нэгж, хорооны иргэд сургалтын болоод бусад үйл ажиллагаандаа ашиглах юм байна.

Мөн ТХБ-II төслийн хүрээнд ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт судалгаа хийх, сургуулийн онцлогт тохирсон сургуульд суурилсан хөтөлбөр боловсруулах, танин мэдэхүйн цахим сан бүрдүүлэх, сургуулийн байрныхаа гуравдугаар давхартаа монгол ахуй, ёс заншлын орчин бүрдүүлэх ажлыг эхлээд байгаагаа мэдээллээ.



ЖИЛД 1,6 САЯ ТӨГРӨГ ХЭМНЭЖ, 9 КГ CO₂ БУУРУУЛЖ БАЙНА

Олон улсын “Эко сургууль” хөтөлбөрийн хүрэл, мөнгө, ногоон туг өргөмжлөлт Орхон аймгийн ерөнхий боловсролын 14 дүгээр сургууль аймгийнхаа эко бүтээгдэхүүн үйлдвэрлэгч “Анд энерги” компанитай хамтран сургуулийнхаа нийтийн эзэмшлийн талбай, цайны газар, номын сан зэрэг 31 өрөө тасалгааны 250 ш улайсах гэрлийг солилоо.

Сургууль нь 1615 ш улайсах болон өдрийн гэрэлтэй бөгөөд үүнийг өдөрт 2 цагаар ажиллуулна гэж тооцвол жилд цахилгаан хэрэгслийн ашиглалтыг оруулаад нийт 8 сая 900 мянга хүртэл төгрөгийг цахилгааны төлбөрт төлж, 49 мянга 560 кг CO₂ ул мөрийг үүсгэж байна. 1615 гэрлийг 600 ширхэг LED гэрлээр солиход жилд дунджаар 3.800619.38 төгрөг хэмнэж, 21.018 кг нүүрстөрөгчийн ул мөрийг бууруулах тооцоо гарч байна.

Үүнээс 250 улайсах болон өдрийн гэрлийг лед гэрлээр сольсноор жилд 1 сая 600 000 гаруй төгрөг хэмнэж, 9 кг нүүрстөрөгчийн ул мөрийг бууруулснаас гадна багш, ажилчид, суралцагчдын эрсдэлгүй, эрүүл аюулгүй орчинд ажиллаж суралцах нөхцөл бүрдэж байна. Цаашид цахилгаан эрчим хүчний хэмнэлтийг харуулсан туршилтын булан байгуулж эцэг эх олон нийтэд эерэг нөлөөллийг бий болгох, түгээхээс гадна сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна гэж мэдээллээ.

Мөн тус сургууль олон улсын “Эко сургууль” хөтөлбөр, ТХБ-II төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд ус цахилгаанаа хэмнэх, зөв дадал хэвшилд суралцах, цахим орчинд эерэг зөв хандлагатай байхыг уриалж “Ус цахилгаанаа хэмнэцгээе” сэдэвт уриалга, гар зураг, зохион бичлэг, видео бичлэг, подкастын уралдааныг бүх сурагчдын дунд цахимаар зохион байгуулсан байна. Уралдаанд Х.Сарантуяа багштай 7а, М.Бямбасүрэн багштай 6в, С.Алтанцэцэг багштай 4д, Ц.Энхтуяа багштай 2б анги хамгийн олон Like, comment /санал, сэтгэгдэл/ авч шилдгээр шалгарлаа.



	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЭЭЛЭЛ СУРГАЛТЫН ТӨВ НҮТББ	Улаанбаатар хот 14210 Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Элчингийн гудамж
		БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН
	Улаанбаатар хот 14191 Сүхбаатар дүүрэг 8-р хороо Энхтайваны өргөн чөлөө-10 Багшийн хөгжлийн ордны 4 давхар	


ДОТООД ОРЧНЫХОО АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛЛАА

ТХБ-II төслийн түшиц сургуулиудын нэг Орхон аймгийн Баян-өндөр сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь сургуулийнхаа дотоод орчны агаарын чанар, аюулгүй байдлыг хангасан хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх зорилгоор “Агаарын чанар-аюулгүй орчин” төслөө амжилттай хэрэгжүүлж байна.

Сургуулийн дотоод орчны бохирдлын шалтгаануудыг судлан тогтоож, түүний хор холбогдлыг таниулах, агаарын чанарыг хэрхэн сайжруулах талаар хэлэлцүүлэг, сургалт, уулзалтаа цахимаар нийт 9 удаа зохион байгуулж 220 гаруй сурагч, эцэг эх асран хамгаалагч, багш нарыг хамруулжээ.

Сургуулийн химийн кабинетын агаарын чанарыг сайжруулахын тулд 4 500 000 төгрөгний үнэ бүхий татах шүүгээг ТХБ-II төслийн санхүүжилтээр авч суурилуулсан бол зарим анги танхимаа ОХУ-ын Bally брэндийн агаар чийгшүүлэгчээр хангаж эхэлсэн байна. Мөн сургууль өөрийн нөөц бололцоог ашиглан эцэг эхчүүдтэйгээ хамтран цонхны хязгаарлагчийг бүх ангиудад хийлээ. Эдгээр ажлын үр дүнд тус сургуулийн дотоод орчны агаарын чанар MNS 4585:2016 стандартын шаардлагыг хангана гэж үзэж байна. Энэ тухай сургалтын менежер Д.Цэнгэл ярихдаа “Бага ангид дунджаар 50 орчим, дунд ангид 40 орчим хүүхэд нэг ангид сууж сурагчдаг. Тиймээс анги бүгчим, агаар сэлгэлт тааруу байх тал бий. Мөн хуурайшилтаас болж байдгаас шороо тоосжилт их байсан. Одоо чийгшүүлэгч тавьж, цонхонд хязгаарлалт хийснээр агаар сэлгэлт сайжирч байна” гэлээ.

5 дугаар сургууль нь нийт 61 бүлэг, 2400-аад сурагчидтай аймгийн томоохон сургуулиудын нэг юм.



15 ДУГААР СУРГУУЛЬ ӨВЛИЙН ХҮЛЭМЖТЭЙ БОЛНО



Орхон аймгийн 15 дугаар сургууль ТХБ-II төслийн хүрээнд “Өвлийн хүлэмж” төслөө амжилттай эхэллээ. Одоогоор хүлэмжнийхээ барилгын ажлын 50 гаруй хувийг гүйцэтгээд байна. Тус хүлэмжийг байгалийн ухааны хичээлд туршилт хийх, орон нутгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах, сурагчдыг амьдрах ухаанд сургах зорилгоор, олон хэлбэрээр ашиглах юм байна.

Орхон аймгийн Байгаль орчны газар, Боловсрол соёл урлагийн газартай хамтран хэрэгжүүлж байгаа “Ногоон Эрдэнэт” төслийн хүрээнд тус сургууль энэ онд 2850 мод тариад байна. Сургуулиа тойруулан 900 шар хуайс, сургуулийн үүдэнд 50 нарс, Бүрэн бүстийн овоонд 650 шинэс мод тарьсан нь сайхан ургаж, орчноо чимж байна.



Мөн хөл хорио, цар тахлын үед суралцагчдыг идэвхжүүлэх, сурах арга барилыг нь дэмжих, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор суралцагчдын дунд “Төрөл бүрийн ургамлын үрсэлгээ хийж тарья” уралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулсан нь үр дүнд хүрчээ. 15 дугаар сургууль нь энэ оны 2 дугаар сард олон улсын “Эко сургууль” хөтөлбөрийн "Ногоон туг" өргөмжлөл, алтан гэрэгээгээр шагнуулсан юм. Хамтран ажиллаж, тусалж дэмждэг Байгаль орчин мэдээлэл сургалтын төвийн хамт олон, Швейцарын хөгжлийн агентлаг, БОАЖГ, орон нутгийн төр захиргааны байгууллага хамт олонд сургуулийн хамт олон талархал илэрхийлж буйгаа ийнхүү уламжилж байна.

И-мэйл: info@feemongolia.mn
Вэбсайт: feemongolia.mn
Утас: +976 88111893

И-мэйл: info@esd.mn
 info@mier.mn
Утас: +976 70125286
 +976 80474838
Вэбсайт: www.mier.mn